**СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 06 дугаар сарын 10 өдөр Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 1:** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн тусламж үйлчилгээний зорилтот түвшнийг бүрэн хангана. /МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.1 2.1.1, МУХЖТ-1.3.1, НХТЖҮЧ-2.9.1, НЗДҮАХ- 2.1.4, НХЖТ-2.8.1, НХЖТ-3.3, СХДЗДҮАХ-2.1, СХНЭХХ-5.1/ | | | | | | | |
| **Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ** | | | | | | | |
| **Зорилт 1.1.** Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх /НЗДҮАХ-2.1, СХДЗДҮАХ-1.1, 2.1/ | | | | | | | |
| 1.1.1 | Хүн амд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахимаар болон танхимаар зохион байгуулах | Байгууллагын төсөв 15.0 | Сургалтын тоо | 60 | 62 | Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа, өдөрлөг арга хэмжээнүүдийг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж эхний хагас жилийн байдлаар 29 сургалт, сурталчилгааны ажил зохион байгууллаа. Цахим хэлбэрээр нийт 187 удаагийн мэдээлэл байршуулсан байна. Зураг постер хэлбэрээр 147, видео хэлбэрээр 15 удаагийн сурталчилгааны материал оруулж нийт 432 мянган хүнд хүрч, 2,3 сая удаагийн үзэлт авсан байна.<br><br>Сургалт, өдөрлөг арга хэмжээнд нийтдээ 2964 иргэнийг хамруулсан байна. | 29 |
| | | | Хамруулсан хүний тоо | 7000 | 7500 | | 2964 |
| | | | Цахим сүлжээнд байршуулсан зөвлөгөө, мэдээллийн тоо | 150 | 200 | | 162 |
| | | | Цахимаар мэдээлэл авсан хүний тоо | 983 мянга | 100 мянга | | 432 мянга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цахим хэлбэрээр “Эмч зөвлөж байна” контентыг үргэлжлүүлэн бэлтгэж Чихрийн шижин өвчин, харшил, осол гэмтлээс сэргийлэх, артерийн даралт ихсэх өвчнөөс сэргийлэх чиглэлээр зөвлөмж бэлтгэж нийт 113 мянган хүнд хүрсэн байна.<br><br>Хэрэгжилт 92.7% | |
| 1.1.2 | Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд өдөрлөг, сургалт зохион байгуулах | Байгууллагын төсөв 30.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 10 | 10 | Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд хагас жилийн байдлаар 6 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Осол гэмтлээс сэргийн сарын аян, хорт хавдартай тэмцэх өдөр, сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр, харшлын эсрэг, артерийн даралттай тэмцэх дэлхийн өдөр, өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд олон нийтэд чиглэсэн ажил арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.<br><br>Хавдартай тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд Хавдар хөнгөвчлөх эмчилгээний тасгийн хамт олон ӨЭМТ-үүдтэй хамтран гэр бүлд нь хавдраар өвдсөн, хөнгөвчлөх эмчилгээнд орох, асаргаа сувилгаа авах шаардлагатай иргэдэд зориулсан өдөрлөг зохион байгуулж хавдрын эмчийн үзлэг, зөвлөгөө, гэрийн нөхцөлд сувилахуйн асаргаа үйлчилгээ үзүүлэх талаар сургалт, мэдээлэл өгсөн. Арга хэмжээнд нийт 31 хүн хамрагдсан.<br><br>Хорт хавдартай тэмцэх, осол гэмтлээс сэргийлэх, артерийн даралт ихсэх өвчнөөс сэргийлэх, харшлаас сэргийлэх, сүрьеэ өвчнөөс сэргийлэх, өсвөр үеийн эрүүл мэндийн | 6 |
| | | | Хамруулсан хүний тоо | 2753 | 9000 | | 7300 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэдвээр мэргэжлийн эмч нар иргэдэд зориулсан видео зөвлөгөө контент хийж цахим орчинд байршуулж иргэдэд сурталчиллаа.<br><br>Өдөрлөг арга хэмжээний олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд цахим болон танхимаар нийтдээ 7300 хүнийг хамруулсан байна.<br><br>Хэрэгжилт 100% | |
| 1.1.3 | Өвчний хяналт, сэргийлэлтийн танхимаар дамжуулан иргэдэд артерийн даралт ихсэх, чихрийн шижин өвчнөөс сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх, эрүүл зан үйл төлөвшүүлэх ганцаарчилсан сургалтад хамруулах | Байгууллагын төсөв 1.0 | АГ, ЧШ өвчний эрсдэлийн үнэлгээнд хамруулсан хүний тоо | 325 | 488 | Артерийн гипертензи, чихрийн шижин өвчний эрсдэлийг бууруулах, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх чиглэлээр 2 удаагийн өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж 171 хүнд артерийн даралтын хэмжилт хийж, БЖИ тооцож, захын судсанд сахар тодорхойлж эрсдэлийг тооцож зөвлөгөө өгсөн.<br>Хэрэгжилт 51.4% | 171 |
| | | | Өвчний эрсдэлтэй хүний тоо | 56 | 84 | | 83 |
| | | | Зөвлөгөө, сургалтад хамрагдсан хүний тоо | 25 | 84 | | 15 |
| | | | Эрсдэлийн түвшин буурсан хүний тоо | 10 | 42 | | 0 |
| 1.1.4 | Өсвөр үеийн үе тэнгийн сургагчдыг чадавхжуулах, нөхөж бэлтгэх | Байгууллагын төсөв 2.0 | Бэлтгэсэн үе тэнгийн сургагчийн тоо | 90 | 30 | Нийгмийн эрүүл мэндийн алба, Өсвөр үеийн кабинет хамтран 2024 онд өсвөр үеийн 90 сургагч бэлтгэж гаргасан. 2025 онд Өсвөр үеийнхэнд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн 2 ажилд татан оролцуулж хамтран үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд 154, 9 дүгээр сургуульд ажилласан. 2025 оны хоёрдугаар хагаст нэмж 30 сурагчийг бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>Хэрэгжилт 50% | 0 |
| | | | Чадавхжсан үе тэнгийн сургагчийн тоо | - | 90 | | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.5 | Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Байгууллагын төсөв 2.0 | Зохион байгуулсан сургалтын тоо | 10 | 6 | Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг сургуулийн нийгмийн ажилтнууд, эмч нартай хамтран зохион байгуулж нийт 6 сургуульд ажиллаж өсвөр үеийнхэнд электрон тамхины хэрэглээний хор уршиг, нөхөн үржихүйн эрүүл мэнд, охидын эрүүл мэнд, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, сэтгэл хөдлөлийн чадамж зэрэг сэдвээр танхимын сургалт зохион байгууллаа. Сургалт, өдөрлөг үйл ажиллагаанд нийт 485 хүүхдийг хамруулсан.<br><br>Өсвөр үеийг сонсъё, ойлгоё аяны хүрээнд цахим нөлөөллийн ажлыг дүүргийн хэвлэл мэдээллийн албатай хамтран видео зөвлөмж бэлтгэж дүүрэг болон эмнэлгийн цахим пэйж хуудсаар түгээсэн. Нийт 5600 хандалт авсан байна.<br><br>Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх стандарт асуумжаар судалгаа явуулж нийт 278 сурагчийг хамруулсан. Тайлангийн жилийн хоёрдугаар хагаст үр дүнг боловсруулахаар ажиллаж байна.<br><br>Өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлсэн хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч 278 хүнд эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөө, мэдээллийг өгсөн.<br><br>Хэрэгжилт 87.8% | 8 |
| | | | Хамруулсан хүний тоо | 1280 | 800 | | 485 |
| | | | Мэдлэгийн ахицын хувь | - | 30% | | |
| 1.1.6 | | | Судалгааны тоо | - | 1 | | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Өсвөр насны охидын жирэмслэлтийн судалгаа хийх | Байгууллагын төсөв 0.5 | Судалгааны дагуу хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | - | 90% | Судалгааны асуумжийг боловсруулах шатандаа явагдаж байна. Тайлангийн жилийн хоёрдугаар хагаст үр дүнг гаргана. | 0 |
| 1.1.7 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон жирэмсэн эхчүүдэд гэр бүл төлөвлөлт, эх, хүүхдийн эрүүл мэнд, жирэмсэн эхийн гэр бүл, асран хамгаалагч нарын оролцоог дэмжих чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах | Байгууллагын төсөв 3.0 | Сургалтын тоо | 6 | 20 | Жирэмсний хяналтад орсон эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 8 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгууллаа. Нийт 185 эмэгтэйг хамрууллаа.<br><br>Зөвлөх эмчээр нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, өсвөр насны охид, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан цуврал зөвлөмжүүдийг бэлтгэж дүүргийн пэйж хуудас болон эмнэлгийн пэйж хуудсаар түгээсэн. Нийт 3 удаагийн зөвлөгөө явуулж 15000 хүнд хүрсэн байна. | 8 |
| | | | Хамруулсан хүний тоо | 420 | 600 | | 185 |
| | | | Цахимаар зөвлөгөө мэдээлэл түгээсэн тоо | 20 | 15 | | 3 |
| | | | Мэдээлэл авсан хүний тоо | 450 мянга | 200 мянга | | 15 мянга |
| | | | Ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгсөн ар гэрийн хүний тоо | 5 | 10 | | 2 |
| 1.1.8 | Хавдар хөнгөвчлөх эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл заслын эмчилгээг явуулах | Байгууллагын төсөв 0.5 | Сэтгэл заслын үйлчилгээ авсан хүний тоо | 40 | 60 | Хавдар хөнгөвчлөх эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч нартай чиглэсэн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл заслын үйл ажиллагааг 3 удаа зохион байгуулж 12 хүнийг хамруулсан.<br>Хэрэгжилт 40% | 12 |
| 1.1.9 | Ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих үүднээс “Сэтгэл зүйчийн цаг”-ийг ажиллуулах, сэтгэл зүйн зөвлөгөөний аргад ашиглагдах хэрэглэгдэхүүнээр хангах | Байгууллагын төсөв 2.0 | Зөвлөгөө авсан ажилтны тоо | - | 50 | Ажилтнуудын ажлын байран дахь сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үүднээс сэтгэл зүйч бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг өгч эхний хагас жилд 4 тасагт ажиллаж 87 ажилтанд ажлаас халшрах хам шинжээс сэргийлэх, стрессийг зөв зохицуулах, мэдрэмжээ илэрхийлэх зэрэг сэдвээр сургалт, зөвлөгөө өглөө.<br>Хэрэгжилт 80% | 87 |
| | | | Сэтгэл зүйн тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн хүний тоо | - | 40 | | 2 |
| | | | Хэрэглэгдэхүүний хангалтын хувь | 50% | 100% | | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.10 | ДЭМБ-ын Сэтгэц мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийг хэрэгжүүлэх чиглэлээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай хамтарч ажиллах, сургалт зохион байгуулах | Байгууллагын төсөв 0.5 | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 1 | ДЭМБ-ын сэтгэц, мэдрэл донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хөтөлбөрийн сургалтад сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар хамрагдсан.<br><br>ӨЭМТ-ийн эмч нарт 1 удаагийн сургалт зохион байгуулж 11 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.<br>Хэрэгжилт 86.7% | 1 |
| | | | Хамруулсан анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтны тоо | - | 14 | | 11 |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | - | 10 | | 3 |
| 1.1.11 | “Эмч зөвлөж байна” контентыг бэлтгэж эмнэлгийн пэйж хуудас, мэдээллийн хэрэгслээр түгээх | Байгууллагын төсөв 2.0 | Бэлтгэсэн контент | 11 | 15 | “Эмч зөвлөж байна” видео контентыг эхний хагас жилд 11 бэлтгэж дүүргийн Сонгинохайрхан мэдээ пэйж болон эмнэлгийн пэйж хуудсанд байршуулж олон нийтэд хүргэсэн. Осол гэмтлээс сэргийлэх, дааврын өвчин, хавдраас сэргийлэх, сүрьеэ өвчнөөс сэргийлэх, угаарын хийн хордлогын үед үзүүлэх тусламж, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд зориулсан зөвлөгөө зэрэг сэдвийн хүрээнд бэлтгэж нийт 149,778 хандалт авсан байна.<br>Хэрэгжилт 100% | 11 |
| | | | Хандалтын тоо | 35 мянга | 46 мянга | | 149 мянга |
| 1.1.12 | Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний таагүй үзүүлэлтээс сэргийлэхэд лавлагаа шатлалын эмнэлэг болон анхан шатны эрүүл мэндийн | Байгууллагын төсөв 3.0 | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөний тоо | - | 2 | Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр нэгдсэн эмнэлгийн холбогдох тасаг, албадын ахлахууд, ӨЭМТ-өөс Төв, Толгойт бүсийн дарга нар, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд оролцсон уулзалт зохион байгууллаа.<br><br>Уулзалтаар сүүлийн 3 жилийн эх нярайн таагүй үзүүлэлтийн мэдээ, шалтгаан, тулгамдаж буй | 1 |
| | | | Оролцсон хүний тоо | - | 70 | | 23 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагууд, Хорооны Засаг дарга, нийгмийн ажилтнуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, ажлын саналыг хэрэгжүүлж ажиллах | | Ажлын саналыг хэрэгжүүлж ажилласан хувь | - | 100% | асуудлуудыг хэлэлцсэн. Цаашид эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр ӨЭМТ-ийн жигд оролцоог хангах, хариуцлагыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх тал дээр шийдвэрт хүрлээ.<br><br>Тус уулзалтаар хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг ӨЭМТ-д шилжүүлж хянахаар нөхөн үржихүйн кабинетад хянагдаж буй 1783 жирэмсэн эмэгтэйн 3% буюу 53 жирэмсэн эмэгтэйг эхний байдлаар ӨЭМТ-ийн хяналт руу шилжүүллээ.<br><br>Цаашид хянагдаж буй жирэмсэн эмэгтэйчүүдийн 30%-ийг ӨЭМТ-д шилжүүлж хянахаар шийдвэрт хүрлээ. Мөн гэрийн төрөлтийн тохиолдлыг бууруулах зорилгоор 36 долоо хоног хүрсэн жирэмсэн эмэгтэйчүүдэд 40 долоо хоног хүртэл ӨЭМТ долоо хоног бүр гэрийн эргэлт хийж таагүй үзүүлэлтээс сэргийлэхийг зөвлөмж болголоо. Нийслэлийн ЭМГ-ын даргын А/94 Хариуцлагатай сонголт аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулж хамтран ажиллахад санал солилцлоо. | 100% |
| 1.1.13 | Амь тэнссэн үеийн суурь тусламж үзүүлэх сургалтыг эмнэлэг, сургууль, байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудад зохион байгуулах | Байгууллагын төсөв 2.0 | Сургалтад хамрагдсан байгууллагын тоо | 1 | 6 | Эхний хагас жилд амь тэнссэн үеийн суурь тусламж үзүүлэх сургалтыг дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн ажилтнуудад зохион байгуулж нийт 69 ажилтан албан хаагчдыг хамрууллаа.<br><br>Эмнэлгийн хэмжээнд амь тэнссэн үед үзүүлэх яаралтай тусламжийн бэлэн байдалд 1 удаа | 1 |
| | | | Сургалтад хамрагдсан хүний тоо | 76 | 300 | | 69 |
| | | | Мэдлэгийн түвшин ахисан хувь | - | 40% | | 20% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээ хийсэн. Blue code идэвхжүүлэх дундаж үнэлгээ 45,1%, Crash cart дундаж үнэлгээ 76,7%-тай тус тус үнэлэгдлээ.<br>Хэрэгжилт 33.1% | |
| **Зорилт 1.2.** Халдварт өвчний болон шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, чадавхыг тогтвортой хангах. /АХ-2.2.2, НЗДҮАХ-2.1, СХДЗДҮАХ-1.1, 2.1/ | | | | | | | |
| 1.2.1 | Улирлын чанартай томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулах | Байгууллагын төсөв 8.0 | Зохион байгуулсан сургалтын тоо | 16 | 15 | Улирлын чанартай томуу, томуу төст өвчин, Улаанбурхан халдварт өвчний дэгдэлтийн үед сургууль, цэцэрлэг, олон нийтэд халдвараас сэргийлэх заавар, зөвлөмжийг эмнэлгийн пэйж хуудсаар тогтмол мэдээлж ажилласан.<br><br>Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх чиглэлээр цахим орчинд 13 удаагийн постер мэдээлэл оруулж 130 мянган хүнд хүрсэн.<br><br>Сургуулийн хүүхдүүдэд 7 удаагийн сургалт зохион байгуулж 210 хүүхдийг хамруулсан.<br><br>Улаанбурхан халдварт өвчний дэгдэлтийн үед Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/342, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/115 тоот тушаалын үндэслэн Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн захирлын 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр “Бэлэн байдал хангах тухай” А/71 тоот тушаалаар“Шуурхай удирдлагын багийн бүтэц, чиг үүрэг”-ийг нэгдүгээр, “Тууралтад халдварын үед ажиллах хариу арга хэмжээний заавар”-ыг хоёрдугаар, “Улаанбурхан өвчний халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г гуравдугаар хавсралтаар батлуулан шуурхай удирдлагын багийн эрчимжүүлэн ажиллаж байна. 2025 оны 03 | 7 |
| | | | Хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо | 19 | 6 | | 6 |
| | | | Хамруулсан хүний тоо | 618 | 800 | | 210 |
| | | | Нийгмийн сүлжээнд сурталчилгаа, мэдээлэл хийсэн тоо | 36 | 36 | | 13 |
| | | | Хандалтын тоо | 617 мянга | 600 мянга | | 130 мянга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 20-ны өдөр Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн захирлын А/18 тоот “Эмчилгээ үйлчилгээг зохицуулах тухай” тушаалыг гарган Яаралтай тусламжийн тасгийн бүртгэлийн хэсэгт захиргааны хэсгийн ажилчдыг томилон ажиллаж байна.<br><br>Хэрэгжилт 72.9% | |
| 1.2.2 | Сүрьеэ өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна | Глобал сан 2.0 | 10.000 хүн амд ногдох илрүүлэлт /промиль/ | 15.7 | 16.0 | 2025 оны эхний хагас жилд сүрьеэгийн диспансерт нийт 165 хүн диспансерын хяналтад орсон. Шинээр илрүүлсэн уушгины сүрьеэ 59, уушгины бус эрхтний сүрьеэ 15 бүртгэгдлээ. 0-14 насны хүүхдийн сүрьеэгийн өвчлөл бүртгэгдээгүй.<br><br>Сүрьеэгийн диспансерт хяналтад байгаа үйлчлүүлэгчдийн хавьтал 161 хүн бүртгэгдсэнээс 0-14 насны хүүхэд 87 байна. Хавьтлын үзлэг шинжилгээнд 121 буюу 75.1%-ийг үзлэгт хамруулсан. Хавьтлын IGRA шинжилгээгээр 44 хүн эерэг гарч 22 хүнийг далд халдварын эмчилгээнд хамруулсан. 0-16 насны 42 хүүхэд далд халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсанаас 14 хүүхэд эерэг гарч эмчилгээнд орсон.<br><br>Тайлангийн жилд цээжний зураг 15,874, сорил 292, түрхэц 837, эксперт шинжилгээ 604 удаа хийсэн байна.<br><br>Сүрьеэгийн эмчилгээнээс эдгэрч гарсан 70 хүн байна. Эмчилгээ үр дүнгүй болсон 6, эмэнд тэсвэртэй сүрьеэд шилжсэн 2 тохиолдол байна. | 8.7 |
| | | | Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь | 83% | 84% | | 84% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 онд Эрүүл мэндийн яамнаас Нэгдсэн эмнэлэгт хиймэл оюун ухаанд суурилсан зөөврийн рентген аппарат олгосон. Сүрьеэгийн илрүүлэг үзлэгт аппаратыг ашиглаж байна.<br><br>Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 12 удаа зохион байгуулж 1706 иргэнийг хамруулсан. Үүнээс сүрьеэгийн халдвар оношлогдсон 4 тохиолдолд очиж хавьтлын үзлэг зохион байгуулсан. Нийт урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдээс 28 хүнээс цэрний шинжилгээ, 32 далд халдвар илрүүлж эмчилгээнд, 7 хүний нян судлалын шинжилгээнээс сүрьеэгийн халдвар илрүүлсэн.<br><br>Олон нийтэд сүрьеэ өвчнөөс сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж 200 хүнд мэдээлэл өглөө. Мөн дүүргийн хэвлэл мэдээллийн албатай хамтран сүрьеэ өвчний талаар мэргэжлийн эмчийн зөвлөгөөг хүргэж нийт 5763 хүн үзсэн. ӨЭМТ-ийн эмч болон тасгийн эмч нарт сургалт зохион байгуулж 45 хүнийг хамруууллаа.<br><br>Хэрэгжилт 100% | |
| 1.2.3 | БЗДХ-ын илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна | Байгууллагын төсөв 5.0 | 10.000 хүн амд ногдох илрүүлэлт /промиль/ | 31.9 | 29.0 | БЗДХ-ын кабинетаар эхний хагас жилд нийт 5256 амбулаторийн үзлэг хийсэн. Үзлэгээр нийт 332 БЗДХ-ын шинэ тохиолдол бүртгэгдсэн. Амбулаторийн үзлэг, халдварын илрүүлэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өссөн | 18.0 |
| | | | Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь | 100% | 100% | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүнтэй байна. Үзлэг 33%-иар, халдварын тохиолдол 26%-иар өссөн байна.<br><br>Үүнээс тэмбүүгийн халдвар 146 (44%), заг хүйтэн 66 (19.8%), трихомониазын халдвар 78 (23.4%), бусад халдвар 42 (12.6%) тус тус илрүүлсэн.<br><br>Нийт 247 хавьтал илрүүлж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br>Хэрэгжилт 100% | |
| **Эмнэлгийн тусламж, үйлчилгээ** | | | | | | | |
| **Зорилт 1.3** Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн хүртээмж, чанарыг сайжруулах /АХ-2.2.11, 2.13, СХДЗДҮАХ-2.1.2/ | | | | | | | |
| 1.3.1 | Амбулаторийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах | Байгууллагын төсөв 55.0 | Сонсголын кабинет | - | 1 | 2025 оны 06 сард сонсголын кабинетыг нээсэн.Сонсгол судлалаар 2 эмч бэлтгэгдэн, 10 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| | | | Бөөрний кабинет | - | 1 | Бөөр судлалаар төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 1 эмч хамрагдаж байна. | 50% |
| | | | Гэмтлийн кабинет | 1 | 2 | Амбулатор-1 дээр Гэмтэлийн 2 кабинет үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Амбулаторийн хүлээгдэл дунджаар 4 хоног болж, 1 дахин буурсан байна. | 100% |
| | | | Арьс харшлын кабинет | 1 | 2 | Арьс харшлын 1 кабинеттайгаар тогтмол үйл ажиллагааг хүлээгдэлгүй үзүүлж байна. | - |
| | | | Дотоод шүүрлийн кабинет | 1 | 2 | Хүний нөөцийн төлөвлөлтөөр 2025-2026 оны сургалтын жилд сургахаар төлөвлөсөн байна. | 20% |
| | | | Чихрийн шижингийн нүдний хүндрэлийн илрүүлэг үзлэг | 554 | 650 | 2024 онд 9-11 сард Чихрийн шижингийн нүдний хүндрэлийг эрт үед нь илрүүлэх үзлэгт 554 өвчтөн хамруулсан. Шинээр хяналтанд 418 өвчтөн хяналтанд орсноос 114 хүнд чихрийн шижингийн нүдний хүндрэлийн үзлэг хийгдсэн.Нийт 668 өвчтөн хамрагдсан. | 57.6% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хүүхдийн зүрх судас | - | 100 | Амбулаторийн Хүүхдийн зүрхний кабинет 2025 оны 03 сарын 20-ны өдрөөс нээн,206 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн.Үүнд:<br><br>○ Эрүүл хүүхэд – хүүхэд-159<br>○ ASD / *atrial septal defect* / - 13 хүүхэд<br>○ PDA / patent ductus arterosus/ - 9 хүүхэд<br>○ Зүрхний хагалгаанд ороод давтан үзлэг-10<br>○ Шинээр зүрхний Хавсарсан гажиг оношлогдсон 1 / яаралтай хагалгаа төлөвлөгдсөн/<br>○ Уушгины венийн буруу оролт -1 хүүхэд / давтан үзлэг/<br>○ PFO / *patent foramen ovale* /- 8 хүүхэд буюу хүүхдийг<br>○ Зүрхний хэм алдагдал 2<br>○ Судасны гажиг -1<br>○ Шенлейн генохын өвчин -2 | 100% |
| | | | Хүүхдийн бөөр шээсний замын эмгэг | - | 80 | Амбулаторийн Хүүхдийн бөөр шээсний замын эмгэгийн кабинетыг 2025 оны 03 сарын 20-ны өдрөөс нээн, 29 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| | | | Хүүхдийн мэдрэл судлал | - | 80 | Амбулаторийн Хүүхдийн мэдрэлийн кабинет 2025 оны 03 сарын 20-ны өдрөөс нээн,110 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн | 100% |
| | | | Хүүхдийн уушги судлал | - | 100 | Амбулаторийн Уушги судлалын кабинетыг 2025 оны 03 сарын 20-ны өдрөөс цагийн менежмент хийн, 72 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| | | | Нярайн үзлэг | - | 40 | Амбулаторийн Нярай хүүхдийн кабинетийг 2025 оны 03 сарын 20-ны өдрөөс нээн, 76 хүүхэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хүүхдийн зүрхний эхо | - | 50 | 2025 оны эхний сарын байдлаар хүүхдийн тасгийн хүүхдийн зүрхний эмч Б.Баасансүрэн эмч нь нийт 206 хүүхдэд үзлэг хийсэн байна. Үүнээс :<br><br>- Эрүүл хүүхэд – хүүхэд-159<br>- ASD / *atrial septal defect* / - 13 хүүхэд<br>- PDA / patent ductus arterosus/ - 9 хүүхэд<br>- Зүрхний хагалгаанд ороод давтан үзлэг-10<br>- Шинээр зүрхний Хавсарсан гажиг оношлогдсон 1 / яаралтай хагалгаа төлөвлөгдсөн/<br>- Уушгины венийн буруу оролт -1 хүүхэд / давтан үзлэг/<br>- PFO / *patent foramen ovale* /- 8 хүүхэд буюу хүүхдийг<br>- Зүрхний хэм алдагдал 2<br>- Судасны гажиг -1<br>- Шенлейн генохын өвчин -2<br><br>Зүрх судасны үзлэг болон эход хамрагдсан нийт хүүхдийн **77% нь эрүүл**, үлдсэн хэсэгт төрөлхийн болон олдмол зүрх судасны эмгэг, гажиг илэрсэн байна.<br>Ховор тохиолдлын хувьд уушгины венийн буруу оролт, хавсарсан гажиг зэрэг оношлогдсон бөгөөд тэдгээрийг мэргэжлийн төв рүү чиглүүлэн, яаралтай болон төлөвлөгөөт эмчилгээний менежментийг зохион байгуулсан.<br>Мэс заслын дараах хяналт, хэм алдагдлын зөвлөгөө, эмийн зохицуулалт, урьдчилан сэргийлэх үзлэгт гол анхаарлыг хандуулж ажилласан болно. | 206 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хүүхдийн түнхний эхо | | 50 | Монгол Швейцарын хамтарсан төслийн хүрээнд Нярайн түнхний хэт авиан эрт илрүүлэг, оношилгооны кабинетыг дүүргийн эмнэлгүүдээс анх удаа үйл ажиллагаа явуулж эхэлсэн.<br>Төслийн хурээнд 9 эмчийг нярайн түнхний хэт авиан оношилгооны чиглэлээр сургаж бэлтгэсэн.<br>Тус кабинет нь орчин үеийн хэт авиан аппаратаар тоноглогдсон бөгөөд олон улсын стандартад нийцсэн оношилгоог 2025 оны 5 сарын 16-аас эхлэн үзүүлж байна. Нийт үзлэг-10. Үүнээс түнхний дутуу хөгжил -1 анх шинээр оношлогдсон. | 100% |
| 1.3.2 | Явуулын нүүр амны тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх | ЭМЯ-ны хөрөнгө оруулалт 80.0 | Тоноглогдсон явуулын автобусаар хангах | - | 1 | Төлөвлөгөөт хугацаанд | - |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | - | 300 | | |
| 1.3.3 | Хавдрын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалт Байгууллагын төсөв 20.0 | Хавдрын хими эмчилгээний үеийн дархлаа дэмжих эмчилгээг нэвтрүүлэх /тусламж үйлчилгээ үзүүлсэн хүний тоо/ | - | 10-аас доошгүй | Тендерийн дагуу эмийн захиалгад Атезолизумаб тарилгын хэлбэрийг захиалсан Эрүүл мэндийн яамны зөвшөөрөл олгогдсон тохиолдолд дархлаа дэмжих эмчилгээг эхлүүлэх бүх бэлтгэл хангагдсан. | 20% |
| | | | Хавдрын үеийн даавар эмчилгээг нэвтрүүлэх/тусламж үйлчилгээ үзүүлсэн хүний тоо/ | - | 30-аас доошгүй | Тайлангийн хугацаанд хавдрын даавbooр эмчилгээг нийт 54 өвчтөнд хэрэгжүүлсэн бөгөөд энэ хүрээнд:<br>- Золадекс 3.6 мг<br>- Фаслодекс 250 мг/5 мл<br>Эмчилгээг тус тус нэвтрүүлэн хэрэглээнд ашигласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хавдрын туяа эмчилгээний төсөл хэрэгжүүлэх суурь судалгаа хийх | - | Судалгаа, төсөл | Хавдрын туяа эмчилгээний CYBERKNIFE аппарат,LINAC аппаратны талаар судалгаа хийн, төсөл боловсруулсан. Хуучин аппарат 1.5 сая ам долларын, шинэ аппарат 7.5 сая ам долларын өртөгтэй байна. | 100% |
| | | | Хавдрын мэс заслын тусламж, үйлчилгээг өргөжүүлж, тусламж, үйлчилгээ авсан хүний тоог нэмэгдүүлэх | 8 | 28 | Хавдарын тусламж үйлчилгээний төвлөрөлийг сааруулах хүрээнд 2025 оны эхний 5 сарын байдлаар:<br>- Элэгний хавдрын мэс засал – 6<br>- Улаан хоолой хавдрын мэс засал – 1<br>- Ходоодны хавдрын мэс засал – 1<br>- Бүдүүн гэдэсний хавдрын мэс засал – 1<br>- Зөөлөн эдийн хавдрын мэс засал – 1<br>- Хөхний хавдрын мэс засал – 1<br>- Элэгний хавдрын эмэн эмчилгээ – 2<br>- Лимфомын хавдрын эмэн эмчилгээ – 1<br>Нийт 14 мэс засал хийгдсэн. | 50% |
| 1.3.4 | Умайн хүзүүний хавдрын CIN I, CIN II үе шатанд LEEP эмчилгээг нэвтрүүлэх, хүний нөөцийг сургах | Байгууллагын төсөв 32.0 | Сургалтад хамрагдсан эмчийн тоо | - | 2 | Хавдар судлалын үндэсний төвөөс "Умайн хүзүүний хавдрын урьтал эмгэгийн оношилгоо, эмчилгээ" сэдэвт 2.5 кредиттэй сургалтад Эмэгтэйчүүдийн эмч Н.Даваажаргал, Нөхөн үржихүйн зохицуулагч эмч П.Солонго нар хамрагдсан. | 2 |
| | | | LEEP эмчилгээ хийсэн хүний тоо | - | 5 | Хийгдээгүй байна. | - |
| | | | LEEP эмчилгээний тоног төхөөрөмж | - | 1 | LEEP эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 1 |
| 1.3.5 | Ходоодны эдийн шинжилгээний үед хеликобактери тодорхойлох Гиймз хистохимийн будгийн аргыг нэвтрүүлэх | - | Шинжилгээ хийсэн сорьцын тоо | - | 5 | Ходоодны эдийн шинжилгээнд *Helicobacter pylori*-ийг илрүүлэх нарийвчлалтай аргуудын нэг болох Гиймз хистохимийн будгийн аргыг 2025 оны 3, 4 дүгээр улиралд багтаан нэвтрүүлэхээр төлөвлөсөн. | - |
| 1.3.6 | | | Орны тоо | 35 | 66 | Гэмтэл хагалгааны нэгдсэн тасаг нь 2024 онд 35 ортой үйл ажиллагаа явуулж байсан ба | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Гэмтэл хагалгааны нэгдсэн тасгийн үйл ажиллагааг өргөжүүлэх | | | | | төвлөрөл сааруулах хүрээнд орны тоог 2025 оны 4 сарын 22-ны өдрөөс нэмэгдүүлэн 74 ортойгоор үйл ажиллагаа явуулж байна. | |
| | | Байгууллагын төсөв 350.0 | Тусламж үйлчилгээ үзүүлсэн нэр төрөл, too | 1070 | 2000 | 2025 оны эхний хагас жилд гар, сарвуу болон хүүхдийн яс-үений чиглэлийн нийт 10 нэр төрлийн мэс заслын тусламж үйлчилгээг **855 өвчтөнд** яаралтай болон төлөвлөгөөт хэвтүүлэн эмчилсэн.<br>**1. Тусламж үйлчилгээний төрөл** — **Тоо хэмжээ**<br>Нийт хэвтэн эмчлүүлсэн — 855<br>➤ Төлөвлөгөөт хагалгаа — 587<br>➤ Яаралтай хагалгаа — 237<br>**2. Мэс заслын төрөл** — **Тоо хэмжээ**<br>1. Гэмтэл согогийн мэс засал — 542<br>2. Чих, хамар, хоолойн мэс засал — 190<br>3. Эрүү, нүүр, амны мэс засал — 123<br>**Нийт мэс засал** — **855**<br>**3. Гүйцэтгэсэн 10 нэр төрлийн мэс заслын жагсаалт**<br>1. Үений холбоос нөхөн сэргээх<br>2. Үений тогтворгүйжилт засах<br>3. Хугарлыг богино хугацаанд хадах<br>4. Хүүхдийн илүү хурууг тайрах, нийлсэн хурууг салгах<br>5. Шууны хугарлыг рентген хяналтан дор ган шөргөөр бэхлэх<br>6. Хүүхдийн шандас, шөрмөс сунгах (төрөлхийн согог засах) | 855 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>7. Хүүхдийн шуу, богтос, доод булууны хугаралыг рентген хяналт дор бэхлэх<br>8. Шууны мэдрэлийн дарагдлыг чөлөөлөх<br>9. Тэнийлгэгч, хугалагч, тасарсан шөрмөс сэргээх<br>10. Гар сарвууны буглаа, үүсгэвэр нээх, хоргүй хавдар авах<br>11. Өвдөг,түнхний үе солих мэс засал<br><br>2025 оны эхний хагас жилд нийт 855 хүнд гар, сарвуу болон хүүхдийн чиглэлийн мэс заслын 10 нэр төрлийн тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнээс 68.7% нь төлөвлөгөөт хагалгаа, 27.7% нь яаралтай хагалгаанд хамрагдсан байна. Гэмтэл согогийн мэс засал зонхилж, нийт мэс заслын 63.4%-ийг эзэлсэн нь осол, гэмтлийн давтамж өндөр байгааг харуулж байна.</td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>Багаж төхөөрөмжийн тоо</td><td>-</td><td>7</td><td>Дээрх 10 нэр төрлийн мэс заслын тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй хүргэхэд нийт 15 ширхэг мэс заслын багц багаж, тоног төхөөрөмж ашиглагдсан.
<table>
<tr><td>№</td><td>Багажийн төрөл</td><td>Тоо, хэмжээ</td></tr>
<tr><td>1</td><td>Гэмтэл согог мэс заслын</td><td>8</td></tr>
<tr><td>2</td><td>ЧХХ мэс заслын</td><td>5</td></tr>
<tr><td>3</td><td>Эрүү нүүрний мэс заслын</td><td>2</td></tr>
<tr><td>4</td><td>Нийт</td><td>15</td></tr>
</table>
Цаашид шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган, холбогдох байгууллагад хүргүүлсэн.</td><td>80%</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрүү нүүрний нэвтрүүлсэн мэс заслын тусламж, үйлчилгээний нэр төрлийн тоо | 4 | 6 | Эхний хагас жилийн байдлаар эрүү, нүүр, амны чиглэлээр нийт **123 мэс засал** хийгдсэн Мэс заслын нэр төрөл:<br>1. Толгой хүзүү орчмын хоргүй хавдар<br>2. Толгой хүзүү орчмын уйланхай<br>3. Толгой хүзүү орчмын нэвчдэс буглаа<br>4. Саатсан шүд болон хоригдмол шүд<br>5. Хэл, уруулын хөвч тайрах, уртасгах<br>6. Шүлсний булчирхайн өвчин<br>7. Тунгалагийн булчирхайн өвчин<br>8. Эрүү, хацар, хамар, нүүрний ясны хугарлын тэгшлэн бэхлэх<br>ЭМДЕГ -тай оношийн хамааралтай бүлгийн гэрээлэлт хийгдсэн. | 100% |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | 136 | 200 | Эхний хагас жилийн байдлаар эрүү, нүүр, амны чиглэлээр нийт 123 мэс засал хийгдсэн | 61.5% |
| | | | Чих хамар хоолой мэс заслын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 9 | 11 | Эхний хагас жилд чих, хамар, хоолойн чиглэлээр **нийт 190 мэс засал** хийгдсэн. Мэс заслын **15 нэр төрлийн** тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:<br>1. Хамрын таславч тэгшлэх<br>2. Самалдаг тайрах<br>3. Шинэ хугарал засах<br>4. Хуучин хугарад засар<br>5. Хамрын хэлбэр нөхөн сэргээх<br>6. Хамар өндөрлөх<br>7. Хамрын дермофак графитаар хамрын хэлбэр нөхөн сэргээх<br>8. Хавирганы мөгөөрсөөр хамрын хэлбэр нөхөн сэргээх<br>9.Таславчийн цоорхой нөхөх<br>10. Элхэг зажуур хөндийг дурангаар нээх<br>11. Тагнайн гүйлсэн булчирхай авах<br>12. Чихний цорго авах<br>13. Чихний буглаа нээх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 14. Хамрын буглаа нээх<br>15. Хоргүй үүсгэвэр авах | |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | 261 | 300 | Эхний хагас жилд чих, хамар, хоолойн чиглэлээр нийт 190 мэс засал хийгдсэн | 63.3% |
| 1.3.7 | Мэс заслын тусламж, үйлчилгээг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах | Байгууллагын төсөв 250.0 | Яаралтай мэс заслын тусламж үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх | 6 | 12 | ЭМС-ын 2025 оны 04 сарын 04-ны өдрийн А/111 тоот тушаалаар СХД-ийн 1-6,18-20,22,23,26,27,29,32-39 хорооны нийт 22 хорооны хүн амд яаралтай мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлж байна | 100% |
| | | | Урологийн мэс заслын тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, дуран, уян дурангийн хангалт хийх | - | 2 | Урологийн мэс заслын тусламж үйлчилгээг хүүхэд,насанд хүрэгчдийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэж байна. Урологийн уян дурангийн захиалгыг НЭМГ, ЭМЯ хүргүүлсэн. | 50% |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | - | 50 | 2025 оны эхний 06 сарын 10-ны өдрийн байдлаар:<br>- Хүүхдийн урологийн мэс засал-14<br>- Насанд хүрэгчдийн урологийн мэс засал-2<br>Нийт 16 хүн урологийн мэс заслын тусламж үйлчилгээнд хамрагдсан. | 32% |
| | | | Дотоод шүүрлийн булчирхайн мэс заслыг нэвтрүүлэх | - | 3 | Бамбай булчирхайн / бүтэн ба хэсэгчилсэн тайрах / мэс засал – 1 хийгдсэн. | 33.3% |
| | | | Гемодиализын судас бэлдэх, хөлийг дахин судасжуулах мэс заслыг өргөжүүлэх , тоног, төхөөрөмжөөр хангах | - | 1 | Чихрийн шижингийн хөлийн хүндрэлийн үед / шарх болон үхжил/ хөлийг дахин судас залгах ,судасжуулах 2 мэс заслыг хийсэн. Гемодиалез эмчилгээнд 3 хүнд хиймэл судас бэлтгэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Багаж, тоног төхөөрөмжийн иж бүрдэл | - | 5 | Мэс заслын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтад дараах нэр, төрлийн иж бүрдэл, төхөөрөмжүүдийг бүрдүүлэн ашиглаж байна. Үүнд:<br>• Нээлттэй хагалгааны хэвлийн том иж бүрдэл – 2 ширхэг<br>• Нээлттэй олгойн мэс заслын иж бүрдэл – 3 ширхэг<br>• Нээлттэй цөсний мэс заслын иж бүрдэл – 2 ширхэг<br>• Зөөлөн эдийн мэс заслын иж бүрдэл – 2 ширхэг<br>• Захын судасны мэс заслын иж бүрдэл – 1 ширхэг<br>• Хэвлийн шарх тэлэгч “Томпсон” – 1 ширхэг<br>• Шамбарам (Hemorrhoidectomy) мэс заслын иж бүрдэл – 3 ширхэг<br>• Дурангийн мэс заслын иж бүрдэл – 3 ширхэг<br>• Дурангийн тоног төхөөрөмж:<br>  ○ Хатуу дуран – 30 градустай – 1 ширхэг, 0 градустай – 1 ширхэг<br>  ○ Дурангийн голч: 10 мм – 1 ширхэг, 5 мм – 1 ширхэг<br>• Урологийн уян дуран – 1 ширхэг<br>• Olympus маркийн дурангийн хагалгааны иж бүрэн цамхаг – 1 ширхэг<br>Шинэчлэл, захиалгын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд: | 11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хэвлийн нээлттэй мэс заслын иж бүрдэл – 2 ширхэг,<br>• Хэвлийн шарх тэлэгч – 1 ширхэг,<br>• Цээжний шарх тэлэгч – 1 ширхэг,<br>• Дурангийн мэс заслын багаж, хэрэгсэл – иж бүрэн багц хэлбэрээр захиалсан. | |
| 1.3.8 | Дүрс оношилгоо болон дүрсийн хяналттай хийх эмчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Мөчдийн судасны хэт авианы шинжилгээг нэвтрүүлэх | - | 1 | 2025 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн дүрс оношилгооны эмч А.Оюунболд мөчдийн судасны эхо шинжилгээний онолын болон практик дадлагын 8 цагийн сургалтанд дүрс оношилгооны 7 эмч хамрагдсан. | 50% |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | - | 500 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар<br>- 14,059 хүнд рентген зураг,<br>- 10,908 хүнд хэт авиан шинжилгээ<br>- 2,398 хүнд компьютер томографийн шинжилгээ<br>- Шүдний дижитал дэлгэмэл рентген зураг -531<br>- Маммографийн шинжилгээ-77<br>- Бамбайн эхо-336<br>Сүрьеэгийн флюрографи -719<br>тус тус хийж, дүрс оношилгооны тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан. Аюултай хариу мэдээлэлийг эхний хагас жилийн байдлаар 13 тохиолдол бүртгэгдсэн. | 50% |
| | | | Хүүхдэд тодосгогчтой компьютер томограф | - | 1 | 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр ЭХЭМҮТ-ийн дүрс оношилгооны тасгаас зохион байгуулсан “Хүүхдийн хоол боловсруулах тогтолцооны шинжилгээ” сэдэвт сургалтад хамрагдаж, улмаар техникч А.Өсөх-Ирээдүй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинжилгээг хийж нэвтрүүлэх | | | хүүхдийн тодосгогчтой компьютер томографийн шинжилгээг хийж эхэлсэн. | |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо | - | 50 | Хүүхдэд тодосгогчтой компьютер томограф шинжилгээг нийт 6 хүүхдэд хийн, хавдарын 2 илэрсэн. | 50% |
| | | | Доод мөчдийн компьютер томограф workstation нэвтрүүлэх | - | 1 | Төлөвлөгөөт хугацаанд | - |
| | | | Бамбай булчирхайн дүрсийн хяналттай эдийн шинжилгээг нэвтрүүлэх | - | 50 | Бамбай булчирхайн дүрсийн хяналттай эдийн шинжилгээг бамбай булчирхайн нарийн зүүгээр хатгалт (FNA) -ийг нийт 17 хүнд хийсэн. Бамбай булчирхайн үүсгэвэрт өөрчлөлтийг үеийн TI-RADS ангилалаар:<br>○ TI-RADS -I ангилал-2 тохиолдол<br>○ TI-RADS-II ангилал -1 тохиолдол<br>батлагдан, 1 өвчтөн мэс засал эмчилгээ хийлгэхээр төвлөгдсөн. | 35% |
| | | | Хөхний хавдрын оношилгоо,эмчилгээ г нэвтрүүлэх | - | 1 | Маммографийн шинжилгээ нийт 77 тохиолдол хийгдсэн.<br>*Шинжилгээний хариу BIRADS үнэлгээгээр*<br>○ BIRADS-I- 37 /шинжилгээнд голомтот өөрчлөлтгүй/<br>○ BIRADS-II- 15 /шинжилгээнд илэрсэн өөрчлөлт хоргүй байх магадлалтай/<br>○ BIRADS-III-23 /шинжилгээнд илэрсэн өөрчлөлт 3-6 сар тутамд эхо шинжилгээгээр хянах, шаардлагатай тохиолдолд биопси хийх/<br>○ BIRADS-IV-4 /шинжилгээнд илэрсэн өөрчлөлт хортой байх магадлалтай, биопси шинжилгээ хийлгэх/ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4 хөхний биопси шинжилгээ эхо хяналтанд хийгдсэн.<br>Эмгэг судлалын хариугаар:<br>o fibroadenoma-1,<br>o A-typical ductal hyperplasia-1,<br>o Myxoid fibroadenoma-1 цаашид 6 сар тутамд эхошинжилгээгээр хянах шаардлагтай. | |
| | | | Ангиографи, MRI төсөл хэрэгжүүлэх судалгаа хийх | - | 2 | Ангиографи болон соронзон резонанс дүрс оношилгоо (MRI)-ны тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт, үйлчилгээний хүрээг өргөжүүлэх зорилгоор төслийн хэрэгцээ, техник эдийн засгийн үндэслэл болон шаардлагатай нөхцөл боломжийг тодорхойлох судалгаа хийгдэж, 2 төсөл боловсруулсан. | 70% |
| 1.3.9 | Дурангийн мэс ажилбар, эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | Байгууллагын төсөв 70.0 | ERCP /endospic retrograde cholangio pancreatography/ ажилбарыг нэвтрүүлэх | - | 10 | Төвлөрлийг сааруулах хүрээнд Улсын 2 дугаар төв эмнэлэгтэй хамтран ERCP (Endoscopic Retrograde Cholangio-Pancreatography) ажилбарыг нэвтрүүлэх зорилгоор гэрээ хийгдсэн. Ажилбар хийх тоног төхөөрөмжийн бэлтгэл хангагдсан. | 50% |
| | | | Хүүхдийн хоол боловсруулах замын уян дуранг өргөжүүлэх | 20 | 100 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар хүүхдийн хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн оношилгоо, эмчилгээг сайжруулах зорилгоор хүүхдийн гастроэнтерологийн эмчийг бэлтгэн, тус чиглэлийн тусламж үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлээд байна. Энэ хугацаанд 10–17 насны 22 хүүхдэд дурангийн шинжилгээ хийсэн. Үүэд:<br>- Улаан хоолойн шарх – 2<br>- Ходоодны шарх – 2<br>- 12 хуруу гэдэсний шарх – 2<br>- Ходоод болон 12 хуруу гэдэсний ургацаг – 1<br>- Улаан хоолойн мөөгөнцөр – 2 | 25% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг эмгэг өөрчлөлтүүдийг илрүүлэн оношлож, цаашдын эмчилгээний менежментийг тодорхойлон ажиллаж байна. Мөн 64 хүүхдэд хүүхдийн гастроэнтерологийн эмчийн үзлэг хийгдсэн. | |
| | | | Бүдүүн гэдэсний уян дуран хийсэн хүний тоо | 57 | 200 | Бүдүүн гэдэсний уян дурангийн шинжилгээг 110 өвчтөнд хийсэн. | 55% |
| | | | Дурангийн ажилбаруудын нэр төрлийг нэмэгдүүлэх | 16 | 180 | Дурангийн ажилбаруудын нэр төрөл, тоо нэмэгдсэн.<br>○ Улаан хоолой, ходоодны уян дуран: 4,019 удаа (Эрт илрүүлэг-2,778, Амбулатори, тасаг-1,178, Урьдчилан сэргийлэх -63)<br>○ Уушгины дуран: 2 удаа<br>○ Бүдүүн гэдэсний дуран: 110 удаа<br>○ Хүүхдийн улаан хоолой, ходоодны дуран: 22 удаа<br>○ Улаан хоолойн өргөссөн венийн судсанд хавчаар тавих ажилбар -2<br>Амьд ахуйн үеийн эдийн шинжилгээ -103<br>ЭМДЕГ-тай дурангийн ажилбарын гэрээлэлт 2025 оны 05 сард хийгдсэн. | 60% |
| 1.3.10 | Үргэлжилсэн бөөр орлуулах эмчилгээг /CRRT/ хэрэгжүүлэх багийг бүрдүүлж тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг бүрдүүлэх | Улсын төсөв (ЭМЯ) | Мэргэжлийн баг | - | 1 | Айвико ХХК -аас Үргэлжилсэн бөөр орлуулах эмчилгээний зарчим, тоног төхөөрөмжийн сургалтыг 2025 оны 06 сард эрчимт эмчилгээний эмч-4, сувилагч-8, туслах сувилагч-3, асрагч-4 хамрагдсан. | 75% |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | 2 | 5 | Эрчимт эмчилгээний тасагт<br>○ Зөөврийн гемодиализ эмчилгээний аппаратаар хангагдсан. Нийт эрчимт эмчилгээний тасагт 20 хүнд гемодиалез эмчилгээ хийсэн./Төслийн хүрээнд / | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ○ Үргэлжилсэн бөөр орлуулах эмчилгээг /CRRT/ аппаратаар тус тус хангагдсан. /Айвико ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд/ | |
| 1.3.11 | Гемодиализын тусламж, үйлчилгээг өргөжүүлэх | Улсын төсөв (ЭМЯ) | Орны тоо | 5 | 11 | Гемодиализ эмчилгээг 5 ортой, 23 хүнд тусламж үзүүлж байсан бол 2025 оны 4 сарын 1-ээс эхлэн 7 ороор нэмэгдүүлж, нийт 12 ортой тусламж үйлчилгээ үзүүлж байна. | 100% |
| | | | Хүний нөөцийн орон тоо | 1 | 2 | 2025 оны хаврын элсэлтээр нэг эмчийг гемодиализын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. | 50% |
| | | | Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо | 2058 | 4000 | Бөөр орлуулах эмчилгээнд 38 өвчтан давхардсан сеансын тоогоор 1515 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 40% |
| 1.3.12 | Эмэгтэйчүүд, БЗДХ-ийн өдрийн эмчилгээг нээн ажиллуулах, өдрийн эмчилгээний нэгдсэн өрөөг засаж, тохижуулах | Байгууллагын төсөв 19.0 | Эмчилгээний өрөөний тоо | - | 1 | Тайлант хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. | - |
| | | | Өдрийн эмчилгээнд хамруулсан хүний тоо | - | 300 | | |
| 1.3.13 | Нөхөн үржихүйн кабинетын тоог нэмэгдүүлж ачааллыг бууруулж, жирэмсний хяналтыг сайжруулах | Байгууллагын төсөв 23.6 | Шинээр нэмэгдсэн кабинетын тоо | 5 | 6 | Жирэмсний хяналтын кабинетийн тоог байгууллагын удирдлагын зөвлөлөөр оруулан орон тоог нэмэгдүүлэн батлуулсан. Ачааллыг тэнцвэржүүлэх,жирэмсний хяналтын чанарыг сайжруулах зорилгоор ӨЭМТ-д хэвийн явцтай 54 жирэмсэн эхийг эхний байдлаар шилжүүлсэн. Цаашид нийт хянагдаж буй жирэмсэн эхийн 30%-ийг шилжүүлэх төлөвлөгөөтэй байна. | 100% |
| 1.3.14 | Эрүүл мэндийн сайдын А/292 тоот тушаал “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”- | Байгууллагын төсөв 330.0 | В-Стрептококк илрүүлэх | - | 1 | Тайлант хугацаанд шаардлагатай аппарат, тоног төхөөрөмжөөр хангагдсан**.** Урвалж, хэрэглэгдэхүүнийг татан нийлүүлэх судалгааны үе шатанд явагдаж байна. | 50% |
| | | | Глюкозын 3 сарын дундаж үзүүлэлт | - | 1 | | |
| | | | Глюкожсон НВ үзүүлэлт | - | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн хэрэгжилтийг хангах болон лабораторийн шинжилгээний үзүүлэлтийг нэмэгдүүлэх | | Бамбайн чөлөөт Т3, Т4, THS үзэх | - | 1 | | |
| | | | Үжлийн маркер | - | 1 | | |
| | | | Шинээр нэмж авсан тоног, төхөөрөмжийн тоо | - | 2 | | |
| 1.3.15 | Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх | - | Шинээр нэмэгдсэн авлагагүй донорын тоо | 97 | 60 | 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан Нэгдсэн Эмнэлгийн Насанд хүрэгчдийн эрчимт эмчилгээний тасаг, Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран “Донорын өдөрлөг”-ийг амжилттай зохион байгууллаа.<br>Тус өдөрлөгийн зорилго нь донорын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сайн дурын донорын эгнээг тэлэх, эмнэлгийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд нийт 80 ажилтан, албан хаагч сайн дураараа оролцож, нийт 240 хүнд амьдрал бэлэглэсэн үр дүнтэй өдөрлөг боллоо. Цус хандивлалтын ач холбогдлыг олон нийтэд таниулах, үлгэр дууриалал үзүүлэх зорилгоор цусны донорын үйлсэд идэвхтэй оролцож, олон хүний амь насыг авран хамгаалсан ажилтнуудаа алдаршуулан танилцуулж, дараах нэр бүхий ажилтнуудад Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс “40, 30, 10 удаагийн донор” тэмдэг, үнэмлэх гардуулан өгсөн. Үүнд:<br>• С. Нандинчимэг – 44 удаа цусаа бэлэглэж, 132 хүний амь авран хамгаалсан<br>• Д. Оюунэрдэнэ – 33 удаа цусаа бэлэглэж, 99 хүний амь аварсан<br>• Б. Нарандэлгэр – 12 удаа цусаа бэлэглэж, 36 хүний амь аварсан<br>• Ж. Соёлмаа – 10 удаа цусаа бэлэглэж, 30 хүний амь аварсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цус цуглуулах үйл ажиллагааг ЦССҮТ-ийн 8 хүний бүрэлдэхүүнтэй хөдөлгөөнт баг зохион байгуулж, Сонгинохайрхан НЭ-ийн хурлын зааланд дараах үе шаттайгаар мэргэжлийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэв. Үүнд:<br>• Донорын бүртгэлийн хэсэг<br>• Донорын эмчийн үзлэгийн хэсэг<br>• ABO, Rh бүлэг тодорхойлох лабораторийн хэсэг<br>• Цус цуглуулах хэсэг<br>• Донорын дараах хяналт, шингэн нөхөх хэсэг<br>• Гарын багц гардуулах хэсэг<br>Тус өдөрлөгөөр дамжуулан Сонгинохайрхан Нэгдсэн Эмнэлгийн хамт олон "Цусаа хандивлаж, амь аврах үйлсэд нэгдэх" өндөр ухамсартай, нийгмийн хариуцлагатай хамт олон гэдгээ батлан харуулж, залуу үеийн төлөөллийг татан оролцуулах, сайн дурын донорын эгнээг өргөтгөхөд бодитой хувь нэмэр оруулсан онцлог үйл ажиллагаа боллоо. | |
| **Зорилт 1.4.** Чанар аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах /АХ-2.2.21/ | | | | | | | |
| 1.4.1 | Албаны үйл ажиллагааны болон эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тооцон, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх | - | Удирдлагын багийн хурлын тоо | 4 | 8 | 2025 онд удирдлагын багийн хурал 2 удаа танилцуулсан.Тус хурлаас 12 шийдвэр гарсан.<br><br>2024 онд эмнэлгийн хэмжээнд 8 чиглэлийн 271 төрлийн эрсдэл бүртгэгдэж байсан бол 2025 оны эхний хагас жилийн байдлаар 357 болж нэмэгдсэн (зарим тасгийн чанарын багийн үйл ажиллагаатай холбоотой жилийн эхэнд эрсдэлийн үнэлгээ хийгээгүй) байна.<br><br>Эмнэлгийн хэмжээнд эрсдэлийн тухайн 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Үр дүнд байгууллагын ажилтан бүр эрсдэлийн талаар | 2 |
| | | | Шийдвэрийн дагуу хэрэгжилтийн хувь | 70.5% | 85% | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ойлголт, мэдлэгтэй болж, ажилтан бүр эрсдлийн үнэлгээг хийн байгууллагын эрсдлийг нэгтгэн, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хамтран ажилласан нь үр дүнтэй байсан. | |
| 1.4.2 | Олон улсын ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны стандарт, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, баталгаажилт авах | Байгууллагын төсөв 20.0 | Дотоод аудитораар бэлтгэгдсэн мэргэжилтний тоо | - | 4 | Байгууллагын дотоод аудит 3 бэлтгэгдсэн. Дотоод аудит хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулж ажилласан. Төлөвлөгөөний дагуу 1 удаа 34 шалгуур үзүүлэлтийн дагуу дотоод аудит хийгдсэн. | 75% |
| | | | Баталгаажилтын гэрчилгээ | - | 100% | ОЛОН УЛСЫН ISO 9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТ хэрэгжүүлэх явцад нийт 17 тасаг, 10 алба, нийт 27 үйл явцын зураглалыг хийж, 6 тасаг ил байршуулсан. Баталгуужуулалтын гэрээ хийхээр хүлээгдэж байна. | - |
| 1.4.3 | Лабораторийн чанар, чадавхад тавигдах шаардлага MNS ISO 15189:2024 нэвтрүүлэх | Байгууллагын төсөв 10.0 | Баталгаажсан байх | MNS ISO 15189:2015 | 90% | MNS ISO 15189:2024 стандартын бэлтгэл ажлын хүрээнд ТАЗ, САЗ, Журмыг шинэчлэн боловсруулж байна.<br>Үүнд:<br>Клиник хими ТАЗ – 19, САЗ – 116<br>Журам – 32, Бактерлогийн САЗ – 20<br>Бүртгэл – 59, Протокол - 5 | 50% |
| 1.4.4 | Эх, хүүхдийн эрүүл мэндийн таагүй үзүүлэлтийг бууруулах чиглэлээр ӨЭМТ-үүдтэй хамтарч ажиллах, дэмжлэгт хяналт хийх, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэлтийг хангаж ажиллах | - | Тохиолдлын тоо | 25 | 20 | 2025 оны эхний 5 сард гарсан таагүй үзүүлэлтүүдийг 9 тохиолдол бүртгэлийн хуудсаар бүртгэж цаг алдалгүй түргэн шуурхай мэдээллийг солилцон ажиллаа. Хаяг андууран бүртгэгдсэн 3 тохиолдлыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт албан бичгээр мэдэгдэж хасуулсан. | 50% |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 92% | 95% | Амьгүй төрөлт хэлэлцэх/хаягаар бүртгэгдсэн 9 тохиолдлоос/ эмнэлзүйн хурлыг зохион байгуулж хурлаас ихэр жирэмсэнд хяналтыг онцгой хийх, ирэх тутам ургийн эхоод харуулах, ургийн эхог сайн харахад мэдлэг мэргэжлээ | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээшлүүлэх тал дээр дүгнэлт шийдвэр гаргасан.<br>- Хурлын ирц-95%<br>- Хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн хувь-80%<br><br>Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгээс ӨЭМТ-ийн дарга, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулж жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээг сайжруулах, таагүй үзүүлэлтээс сэргийлэх чиглэлээр хамтарч ажиллах зохион байгуулалтын ажлуудыг хэлэлцэж, санал солилцох уулзалт зохион байгуулсан. Уулзалтын шийдвэрийн дагуу хэвийн яюцтай жирэмсэн эмэгтэйг ӨЭМТ-үүдэд шилжүүлж эхэлсэн одоогийн байдлаар 53 жирэмсэн эхийг шилжүүлж хэрэгжилт 3%-тай байна. ӨЭМТ-д жирэмсний 36 долоо хоногтойгоос гэрийн эргэлтийг 7 хоног тутам хийж ажиллаж байна | |
| | | | Дэмжлэгт хяналтын тоо | 1 | 4 | Нэг удаагийн дэмжлэгт хяналтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлын талаар мэргэжлийн заавар, зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтэд үндэслэн дахин хяналт үнэлгээ хийхээр төлөвлөн, шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. | 1 |
| 1.4.5 | Мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн дэмжлэгт хяналт, шалгалт, гүйцэтгэлийн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж | - | Дэмжлэгт хяналтын тоо | 6 | - | ХӨСҮТ-ийн 4, НЭМГ-ын 4 удаагийн дэмжлэгт хяналтад хамрагдсан. Үүнээс 2 хяналтын зөвлөмж ирсэний дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.<br>1. 2025 оны 01 дүгээр сард ХӨСҮТ-ээс Томуу, томуу төст халдварын бэлэн байдал, хариу арга хэмжээний хяналт – албан бичгээр зөвлөмж ирээгүй. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг ханган улирал тутам үр дүн тооцох | | | | | 2. 2025 оны 02 дүгээр сард ХӨСҮТ-ээс Амьсгалын замын синциталь вирусын тандалт судалгааны бэлэн байдлын хяналт - албан бичгээр зөвлөмж ирээгүй.<br>3. 2025 оны 03 дугаар сарын 03-ны өдөр НЭМГ-ын Улаанбурхан халдварт өвчний бэлэн байдлыг үнэлэх дэмжлэгт хяналт - албан бичгээр зөвлөмж ирээгүй.<br>4. 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ХӨСҮТ-өөс Улаанбурхан халдварт өвчний бэлэн байдал, хариа арга хэмжээ хяналт - албан бичгээр зөвлөмж ирээгүй.<br>5. 2025 оны 03 дугаар сард НЭМГ-ын мэргэжлийн хяналтаас хоолны хордлогот халдварт өвчин бүртгэгдсэнтэй холбоотой бэлэн байдал, хариу арга хэмжээний хяналт - албан бичгээр зөвлөмж ирээгүй.<br>6. 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын “Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ”-ний чиглэлээр хийсэн дэмжлэгт хяналтад хамрагдаж, 04 дүгээр сарын 29-ний өдөр захиралууд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч нар, ЭМТҮЧАБА тай хурал хийсэн. Хуралд хэлэлцсэн асуудлын дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>7. 2025 оны 04 дүгээр сард НЭМГ-ын Улаанбурхан халдварт өвчний бэлэн байдал хяналт - албан бичгээр зөвлөмж ирээгүй.<br>8. 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн халдварт өвчний тандалт судалгааны албаны тархвар судлаач Б.Соёлмаа, Ж.Эрдэнэбаяр нар Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчдийн дунд улаанбурхан өвчний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой дэмжлэгт хяналт хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотойгоор халдвар тархахаас сэргийлэх, тандалт, хариу арга хэмжээг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгсөн. | |
| | | | Биелэлтийн хувь | 95% | 100% | Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган, тухай бүрт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна. НҮК-д НЭМГ-аас хийсэн дэмжлэгт хяналтын зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний тайланг 2025 оны 06 сарын 18-нд хүргүүлэхээр ажиллаж байна. | 90% |
| | | | Зөвлөмжийн хэрэгжилт | 90% | 100% | | |
| 1.4.6 | Удирдлагын багийг Чанарын сургалтад хамруулах /Сургалтын дагуу аян өрнүүлэх, төлөвлөгөө боловсруулах/ | Байгууллагын төсөв 14.0 | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 2 | 50 | Төлөвлөгөөт хугацаанд | - |
| | | | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | - | 3 | | |
| 1.4.7 | "Амь тэнссэн төлөв" чадварт сургах “BLUE CODE” 1 жилийн аян зохион байгуулж, үр дүнг тооцох | Байгууллагын төсөв 1.0 | Хамрагдсан ажилтны тоо | 352 | 600 | Амь тэнссэн үеийн яаралтай тусламжийн үйлчилгээг (Blue-code, Code-108) идэвхжүүлэх, сайжруулах зорилгоор Crash cart (амь тэнссэн үеийн эмийн иж бүрдэл)-ын бэлэн байдлын хяналт, үнэлгээг хийсэн. Нийт 300 ажилтан хамрагдсан. Код идэвхжүүлэх дундаж хугацаа 6 минут.<br><br>Хяналт, үнэлгээний хүрээнд:<br>• Тасгуудын бэлэн байдлыг шалгаж, үнэлгээ өгсөн,<br>• Илэрсэн зөрчил, дутагдлын талаар ажлын байрны түвшинд заавар, зөвлөмж хүргүүлсэн, | 60.9% |
| | | | BLUE CODE идэвхжих хугацаа | 10 мин | 5 мин | | |
| | | | Амилуулах суурь тусламж үзүүлэх чадварын үнэлгээний хувь | 46.6% | 85% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Бэлэн байдлыг хангах чиглэлээр сайжруулалтын арга хэмжээ авах үүрэг, чиглэл өгч ажилласан.<br><br>(Blue-code, Code-108) идэвхжүүлэх дундаж үнэлгээ-45.1%<br><br>(Crash cart) дундаж үнэлгээ-76.7% | |
| 1.4.8 | Чанар сайжруулах арга хэрэгсэл ашиглан тохиолдлын дагуу арга хэмжээг авах | Байгууллагын төсөв 1.0 | Ашигласан хэрэгслийн тоо | 14 | 14 | ЭМТҮЧАБАлба Таагүй болон ноцтой 7 тохиолдолд чанар сайжруулах арга хэрэгсэл (5 яагаад?) ашигласан. Яаралтай тусламжийн тасгийн тохиолдол хэлэлцүүлэг хийхдээ загасан нурууны арга ашигласан. | 50% |
| | | | Таагүй тохиолдлын тоо | 17 | 14 | ЭМТҮЧАБА-д 2025 оны 05 сарын 30-ны байдлаар таагүй 6 тохиолдол бүртгэгдсэн байна. | 50% |
| | | | Ноцтой тохиолдлын тоо | 10 | 8 | ЭМТҮЧАБА-д 2025 оны 05 сарын 30-ны байдлаар ноцтой 3 тохиолдол бүртгэгдсэн байна. | 50% |
| | | | Эмнэлгийн алдааны тоо | 2 | 1 | Бүртгэгдээгүй. | 100% |
| | | | Тохиолдол хэлэлцүүлгийн | 14 | 15 | Тохиолдлуудын дагуу холбогдох мэргэжилтнүүдтэй тохиолдол хэлэлцүүлэгийг тухай бүрт хийж байна. /яаралтай тусламжийн тасагт-1, өдрийн эмчилгээний тасагт-2, лабораторийн тасагт-1, хавдар хөнгөвчлөх эмчилгээний тасаг - 2, насанд хүрэгчдийн эрчимт эмчилгээний тасаг - 1/. Нийт тохиолдол хэлэлцүүлэг -7 | 50% |
| | | | Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | 14 | 15 | | |
| 1.4.9 | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах 6 зорилтын хэрэгжилтийг үнэлэх (зорилт тус бүрээр) | Байгууллагын төсөв 1.0 | Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журмын хэрэгжилт | 87.6% | 95% | Үйлчлүүлэгчийг танин тодруулах журмын хэрэгжилтийн хяналтыг ЭМТҮЧАБА-аас 7 тасагт хийсэн. Үнэлгээний дундаж 85% байна. | 85% |
| | | | Унах эрсдэлийг үнэлгээний хэрэгжилт | 35% | 90% | Унах эрсдэлийн үнэлгээг эмнэлгийн захирлын 2023 оны 119 дугаар тушаалын дагуу 7 тасагт | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт хийж үнэлэхэд дундаж үнэлгээ 85% байв. | |
| | | | Мэс заслын аюулгүй байдлын хэрэгжилт | 90% | 100% | 2025 оны 1 сарын 17-нд МХНТ-т хийсэн албадын дэмжлэгт хяналтаар ЭМС-ын А/352 дугаар тушаал, Эмнэлгийн захирлын А/119 дугаар тушаалын дагуу:<br>- Мэс заслын өмнөх баталгаажуулалт<br>- Мэс засал, ажилбарын өмнөх /Time out/<br>- Мэс засалын талбайн тэмдэглэгээ<br>Гэсэн ерөнхий 3 агууллагын хүрээнд хяналт хийхэд хэрэгжилтийн дундаж үнэлгээ 83%. | 83% |
| | | | MNS 7014:2023-ын хэрэгжилт | 92% | 100% | Эхний хагас жилийн байдлаар 13 тасагт хяналт хийсэн ба үнэлгээний дундаж хувь 84% байна. | 84% |
| | | | Эмийн аюулгүй байдлын хэрэгжилт | 65.5% | 80% | Өндөр эрсдэлт эм, ижил харагддаг, ижил дуудагддаг эм, эмийн хадгалалт аюулгүй байдал, мансууруулах сэтгэц нөлөөт эм, эмийн харилцан үйлчлэл, гаж нөлөө, эмийн эмчилгээ зардал, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт, хугацаат эмийн самбар, жор бичилт гэх нийт 9 чиглэлийн дэмжлэгт хяналтыг 50 удаа хийсэн ба дундаж үнэлгээний хувь 71% байна. | 71% |
| | | | Эрүүл мэндийн ажилчдыг халдвараас сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт | 44.4% | 80% | ЭМС-ийн 2019.11.29-ний А/537, 2024 оны 05 сарын 21-ний А/230 дугаар тушаалын дагуу халдварын тандалт, хог хаягдал ангилах, цуглуулах, цэвэрлэгээ, өргөлтийн сэргийлэлт чиглэлээр дэмжлэгт хяналт хийсэн. | 69.12% |
| 1.4.10 | Сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэх, иргэдээс гаргасан гомдлыг шийдвэрлэж, арга хэмжээ авч ажиллах | - | Ажилчдын эерэг сэтгэл ханамжийн хувь | 85.8% | 90% | Сэтгэл ханамжийн судалгаа 396 ажилтанаас авсан. Эерэг сэтгэл ханамж 83.7% | 83.7% |
| | | | Үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамжийн хувь | 83.7% | 85% | Үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамж амбулаторийн тасаг 71%- тай, хэвтэн эмчлүүлэх тасгууд 89.5%-тай байна.<br>- Хэвтэн эмчлүүлэх тасгууд 4%-аар өссөн. | 80.25% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Амбулаторийн сэтгэл ханамж 11%-аар буурсан нь тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулахаар үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч ЭМДҮЗ-ын 04-р тогтоол, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношийн хамааралтай бүлгийн гэрээлэлт мөн тусламж үйлчилгээний битүүмж ихээр үүсэж байгаатай холбоотой буурсан байна. | |
| | | | Хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо | 1200 | 1400 | Ерөнхий сэтгэл ханамжийн судалгаанд хэвтэн эмчлүүлэх тасгаас 840 үйлчлүүлэгч, амбулаторийн тасгаас 172 үйлчлүүлэгч хамрагдсан.Нийт судалгаанд 1012 үйлчлүүлэгч хамрагдсан. Хамралтын хувь -72% | 72% |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 83.7% | 90% | Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хүлээгдэл бууруулах, дотоод зохион байгуулалт, цэвэрлэгээ үйлчилгээ, ажилчдын харилцаа хандлага, хоолны амт чанар, ерөнхий сэтгэл ханамжийн нийт 6 чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж байна. | 75 |
| | | | Бүртгэгдсэн гомдлын тоо | 145 | 100 | ЭМТҮЧАБА-д иргэдээс нийт 33 өргөдөл, гомдол (05 сарын 13-ны байдлаар) ирүүлсэн байна. Үүнд: 1111 төвөөс 14 , утсаар 2, амаар-3, бичгээр-14 ирсэн. Үүнээс тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол 15 буюу 45,4%-ийг эзэлж байна. | 77% |
| 1.4.11 | Олон улсын оношилгоо, эмчилгээний зааврыг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах | - | Батлагдсан эмнэл зүйн заавар | 31 | 40 | Төлөвлөгөөт хугацаанд | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.12 | Шинэ технологи, сайн туршлага нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, үр дүнг тооцох | - | Нэвтрүүлсэн сайн туршлагын тоо | 19 | 25 | Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан "Сайн туршлага 2024" арга хэмжээнд оролцсон бүтээлийг танилцуулан, дэлгэрүүлэх" 2025 оны үйл ажиллагааны хүрээнд 14 хоног бүрийн цахим танилцуулга сургалтанд хуваарийн дагуу ЭМТҮЧАБА тогтмол хамрагдаж байна.<br>• 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр СХНЭ сайн туршлагаа нийслэлийн харьяа байгууллагуудад цахимаар танилцуулсан.<br>• Сайн туршлага 2025 арга хэмжээг 2025 оны 4 дүээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн | 50% |
| | | | Хэвшүүлсэн сайн туршлагын тоо | 2 | 5 | НЭМГ, СХДЭМТөв хамтран 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан "Сайн туршлага 2024" арга хэмжээний заавал хэвшүүлэх бүтээлийг танилцуулах үзүүлэх сургалтад Чанарын менежер Б.Бямбасүрэн, Асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Буяндэлгэр, Яаралтай тусламжийн тасгийн эмч Б.Солонго, Хавдар хөнгөвчлөх эмчилгээний тасгийн арга зүйч Ж.Соёлмаа нар хамрагдсан.<br>Яаралтай тусламжийн тасагт Орны дэргэдэх шокийн үнэлгээ хийх эхо аппаратаар хангагдсан. | 50% |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2:** Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх замаар Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. /НХТЖҮЧ-2.5, 2.6, 2.11, НЗДҮАХ-2.1, НХЖТ-2.8.1, НХЖТ-3.3 НСХДЗДҮАХ-2.1, СХДЗДҮАХ-1.1, 2.1/ | | | | | | | |
| **Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.1.** Зорилтот бүлгийн хүн ам эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад онцгой анхаарч ажиллах. Гэр бүлийн гишүүн бүрд эрүүл мэндийн мэдлэг боловсрол олгох, хүн амд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэнэ. НХТЖҮЧ-2.11, НЗДҮАХ-2.1.4**,** СХДЗДҮАХ-1.1, 2.1/ | | | | | | | |
| 2.1.1 | Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг сайжруулах, шинээр оношлогдсон өвчлөлийн хяналтыг нэмэгдүүлэх | - | Эрт илрүүлэг, үзлэгт хамрагдсан иргэдийн тоо | 6763 | 8131 | 2025 оны эхний 5 сарын байдлаар эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд нийтдээ 3796 хүн хамрагдлаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22.9%-иар өссөн дүнтэй байна. Нийтдээ эрт илрүүлэг үзлэгт 29,206 хүнийг хамруулсан. Хамрагдвал зохих хүн амын 33%-ийг хамруулаад байна.<br><br>2025 оны эхний хагас жилд хорт хавдрын 10 тохиолдол илрүүлсэн. Үүнээс ходоодны хавдар 7, бүдүүн гэдэс 2, улаан хоолойн хавдар 1 тус тус илэрсэн.<br><br>Эрт илрүүлэг үзлэгээр хүн амын дундах өвчлөлийн байдал дараах дүр зурагтай байна.<br><br>1. Хоол боловсруулах тогтолцооны өвчин 36,9%<br>2. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд 27,6%<br>3. Шээс бэлгийн тогтолцооны эмгэг 10,3%<br>4. Зүрх судасны тогтолцооны өвчин 5,9%<br>5. Амьсгалын тогтолцооны өвчин 1,7% тус тус ээлж байна.<br><br>Үзлэг хамрагдсан хүн амын 8% эрүүл хүн ам байна.<br><br>2025 онд эрт илрүүлэгт орсон иргэдээс элэгний вируст халдварын 396 тохиолдол бүртгэгдлээ. | 3796 |
| | | | Хамралтын хувь | 28.5% | 37% | | 33% |
| | | | Хорт хавдар оношлогдсон хүний тоо | 21 | 30 | | 10 |
| | | | Илэрсэн БЗДХ-ын сэжигтэй тоо | 75 | 100 | | 2 |
| | | | Эмчилгээнд хамруулсан хувь | 85% | 90% | | 87% |
| | | | ӨЭМТ-ийн хяналтад шилжүүлсэн хүний тоо | 69 | 75 | | 956 |
| | | | Лавлагаа шатлалд илгээсэн хүний тоо | 1200 | 1300 | | 1217 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэрэгжилт 93.3% | |
| 2.1.2 | Жирэмснийг эрт илрүүлж, жирэмсний явцын хяналтыг чанаржуулах, жирэмсний эмгэг хүндрэлийг эрт оношлох, эмчлэх ажлыг тогтмол чанартай зохион байгуулж, ноцтой хүндрэл, таагүй үзүүлэлтийг бууруулах /ЭМС-ын А/292 тоот тушаалын хэрэгжилтийг хангах/ | - | Жирэмсний эрт хяналтын хувь | 94% | 95% | Илүү өртөмхий бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах хуваарийн дагуу эх, барих эмэгтэйчүүдийн эмч нар харьяа ӨЭМТ-үүдэд ажиллаж 12 удаагийн үзлэг зохион байгууллаа. Үзлэгт нийт 823 эмэгтэйчүүдийг хамруулж, 446 эмэгтэйд жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэсэн.<br><br>ЭМС-ын А/292 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, тусламж, үйлчилгээг нийцүүлэх үүднээс дотоодын сургалтыг 1 удаа зохион байгуулж эх барих, эмэгтэйчүүдийн их эмч, бага эмч нарт сургалт зохион байгуулсан.<br><br>2025 оны эхний 5 сард гарсан таагүй үзүүлэлтүүдийг тохиолдол бүртгэлийн хуудсаар бүртгэж цаг алдалгүй түргэн шуурхай мэдээллийг солилцон ажиллаа. Хаяг андууран бүртгэгдсэн 3 тохиолдлыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт албан бичгээр мэдэгдэж хасууллаа. Амьгүй төрөлт хэлэлцэх /хаягаар бүртгэгдсэн 9 тохиолдлоос/ эмнэл зүйн хурлыг зохион байгуулж хурлаас ихэр жирэмсэнд хяналтыг онцгой хийх, ирэх тутам ургийн эход харуулах, ургийн эхог сайн харахад мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх тал дээр дүгнэлт шийдвэр гаргасан.<br><br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 сарын 24 А/292 дугаар тушаалын гуравдугаар хавсралт, 2024 оны 01 сарын 29 А/38 дугаар тушаалын | 94.5% |
| | | | Илүү өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийн ЖСА-д хамрагдсан хувь | 69.5% | 72% | | 61.8 |
| | | | Гэрийн төрөлтийн тоо | 11 | 10 | | 5 |
| | | | Хяналтгүй төрөлтийн тоо | 22 | 18 | | 5 |
| | | | Амьгүй төрөлтийн тоо | 19 | 17 | | 6 |
| | | | Жирэмсний хавсарсан эмгэгийг илрүүлсэн тоо | 1461 | - | | 713 |
| | | | Жирэмсний хавсарсан эмгэгийг эмчилсэн хувь | 81.1% | 85% | | 70% |
| | | | Таагүй үзүүлэлтийн мөрөөр зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо, сургалт | 2 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | наймдугаар хавсралтыг нийлүүлэн сүрьеэ илрүүлэх асуумжийг авч байна. Сүрьеэ өвчин илрүүлэх асуумжаар нэг асуултад “Тийм” гэж хариулбал “Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол” гэж дүгнэж, мэргэжлийн эмчид илгээн ажиллаж байна. Эрсдэлийн асуумжаар 4 оноо авахад эрт илрүүлэх үзлэгт хамруулж байна. Сүрьеэгийн диспансерт үзүүлсэн жирэмсэн эхийн тоо-28, нөхөн үржихүйн кабинетад сүрьеэ оноштой хянагдаж буй жирэмсэн эхийн тоо-4 байна.<br><br>Жирэмсний дотрын кабинетын эмч жирэмсний хяналтын кабинетын эмчтэй хамтран Google sheet-д бүртгэл хийж эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэн эмэгтэйд давхар хяналтыг хийх ажлыг эхлүүлсэн.<br><br>Элэгний В,С вирусийн халдвартай хянагдаж буй эхийн тоо-37, дотрын тасагт хэвтүүлэхээр илгээсэн-20, дээд шатлалд онош тодруулахаар илгээсэн-13 байна. Жирэмсний дотрын эмчийн диспансерын хяналтад эрхтэн тогтолцооны эмгэгтэй 5 жирэмсэн хяналтад байна.<br><br>Архаг эрхтэн тогтолцооны эмгэгтэй, ургийн гажиг эрт, хожуу оношлогдсон, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг үнэлж цаг алдалгүй дээд шатлалд шилжүүлж ажилласан эхийн тоо 2025 оны эхний 5 сарын байдлаар 1682 байна. Өмнөх оны энэ үетэй харьцуулахад 12 хувиар өссөн байна.<br><br>Хэрэгжилт 94.5% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.3 | Илүү өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, өвчтэй илэрсэн эмэгтэйчүүдийг хяналтад авч эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах | Байгууллагын төсөв 5.0 | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо | 1162 | 1200 | Илүү өртөмхий бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах хуваарийн дагуу эх, барих эмэгтэйчүүдийн эмч нар харьяа ӨЭМТ-үүдэд ажиллаж 12 удаагийн үзлэг зохион байгууллаа. Үзлэгт нийт 823 эмэгтэйчүүдийг хамруулж, 446 эмэгтэйд жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэсэн.<br><br>Хэрэгжилт 88.3% | 823 |
| | | | Илэрсэн өвчлөлийн тоо | 763 | 800 | | 581 |
| | | | Эмчлэн эрүүлжүүлсэн хувь | 65% | 68% | | 65% |
| 2.1.4 | 0-5 насны хүүхдийн суурь өвчлөл, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, эмчлэн эрүүлжүүлэх | Орон нутгийн төсөв 2.0 | Хамрагдсан хүүхдийн тоо | 18 | 20 | Хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдийн өвчний түүхэнд эргэмж судалгаа хийж үр дүнг ӨЭМТ-ийн эмч нарт мэдээлсэн. Нийт 746 өвчний түүхэнд судалгаа хийлээ. Судалгааны дүнгээр нийт хүүхдийн 14.8% нь сульдаатай, 36.1% нь цус багадалттай ба 6.4% нь хүнд, хүндэвтэр цус багадалттай байна. Бие бялдрын өсөлтийн үнэлгээнд туранхай, тураалтай хүүхдүүд 5.2%-ийг эзэлж байна. Z оноо -3-аас доош үзүүлэлттэй 1.6%-ийг тус тус эзэлж байна.<br><br>Тураалтай 17 хүүхдүүдийг хоол тэжээлийн эмчилгээнд хамруулж эмнэлгээс гаргасан.<br><br>Хэрэгжилт 100% | 38 |
| | | | Эмчлэн эрүүлжүүлсэн хүүхдийн тоо | 16 | 18 | | 17 |
| 2.1.5 | Өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах, илэрсэн өвчлөлийг эрүүлжүүлэх, үр дүнд | Байгууллагын төсөв 1.0 | Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | 1126 | 1200 | 2025 оны хагас жилийн байдлаар нийт 570 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаас гүйлсэн булчирхайн архаг болон цочмог үрэвсэлтэй 24%, шүд хорхойтох өвчин | 570 |
| | | | Шинээр илрүүлсэн өвчлөлийн тоо | 455 | - | | 467 |
| | | | Эмчлэн эрүүлжүүлсэн хувь | 39% | 50% | | 46% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж, үнэлэх | | Өсвөр үеийн жирэмслэлтийн тоо | 106 | - | 58%, бусад өвчлөл 12% хүүхэд илэрсэн. Нийт өвчлөлийн 46 хувийг эрүүлжүүлсэн байна. Хэрэгжилт 95% | 53 |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 94% | 95% | | 90% |
| 2.1.6 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагчдыг эрт илрүүлэг үзлэгт хамруулах, өвчтэй илрэгсдийг эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх эмчилгээ, дасгалд хамруулан, үр дүнг тооцох | - | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн амын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь | 2% | 4% | 2025 онд эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 3796 хүнээс хөгжлийн бэрхшээлтэй 36 иргэн хамрагдсан байна.<br><br>Сэргээн засах эмчилгээнд 854, уламжлалт эмчилгээнд 1334 иргэнийг хамруулсан. Хэрэгжилт 73.3% | 1% |
| | | | Нөхөн сэргээх эмчилгээ, дасгалд хамрагдсан иргэний тоо | 1672 | 1700 | | 854 |
| | | | Үзлэгт хамрагдсан иргэний тоо | 800 | 500 | | 854 |
| | | | Эмчлэгдсэн хувь | 90% | 90% | | |
| 2.1.7 | Ахмад настныг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчилгээнд хамруулах эрүүл, урт насжилтын талаар ахмад настнуудыг сургалт, сурталчилгаа, мэдээллээр хангах | Орон нутгийн төсөв 1.0 | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ахмад настны тоо | 200 | 1100 | Эрт илрүүлэгт тайлангийн жилд нийт 956 ахмад настан орсон байна. Үзлэг хамрагдсан нийт хүн амын 25.2%-ийг эзэлж байна.<br><br>Ахмад настнуудад зориулсан сургалт арга хэмжээг 1 удаа зохион байгуулж 35 ахмадыг хамруулсан.<br><br>Эрүүл мэндийн сайдын тушаалаар ахмад настны үзлэг зохион байгуулах тухай ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлгийг амбулаторийн тасгийн нарийн мэргэжлийн эмч нар ахмадуудад урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгт нийт 739 ахмад настны хамрууллаа.<br><br>Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгээр орсон ахмадуудаас 59 ахмадыг дараагийн лавлагаа | 1706 |
| | | | Эмчилгээнд хамрагдсан ахмадын тоо | 62 | 275 | | 763 |
| | | | Сургалтын тоо | 5 | 5 | | 1 |
| | | | Нийгмийн сүлжээнд сурталчилгаа, мэдээлэл хийсэн тоо | 14 | 20 | | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатлалд, 152 ахмадыг эмчийн хяналтад, 92 ахмадыг эмчилгээнд хамруулсан.<br><br>Хавдрын эмчийн үзлэгээр уушгины хавдар 3, эмэгтэйчүүдийн хавдар 1 илрүүлсэн.<br><br>108 ахмадад дурангийн оношилгоо хийснээс эдийн шинжилгээнд 18 тохиолдлыг илгээсэн байна. Мэс заслын эмчийн үзлэгээр цөсний чулуу авах заалттай 22, үений мэс засалд орох 8 ахмад байсан.<br><br>Хэрэгжилт 72.5% | |
| 2.1.8 | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийж, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан түүний мөрөөр давтан гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулах | - | Шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг судлан эрсдлийн үнэлгээ хийж хэлэлцсэн хурлын тоо | 2 | - | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн тохиолдол гараагүй. | - |
| | | | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хүчин зүйлийг бууруулах талаар хийгдсэн төлөвлөлт, хэрэгжилтийн хувь | 100% | - | | - |
| | | | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн тоо, хувь | 2 | - | | - |
| | | | Нийт 0-5 насны хүүхдийн дунд хяналтгүй нас | 2 | - | | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баралтын тоо | | | | |
| 2.1.9 | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийн богино болон урт хугацааны эрүүлжилтийн хувь нэмэгдүүлэх | - | 1,2-р ээлжийн богино хугацааны эрүүлжилтийн хувь | - | - | 2025 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын комисст Нэгдсэн эмнэлгийн эмч нар оролцож ажиллаа. Цэргийн байгууллагаас цэрэгт тэнцээгүй залуучуудын эрүүл мэндийн мэдээллийг хараахан ирүүлээгүй байна. Эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг ӨЭМТ, Цэргийн штабтай хамтран хоёрдугаар хагас жилд зохион байгуулна. | 70% |
| | | | 1,2-р ээлжийн урт хугацааны эрүүлжилтийн хувь | - | - | | |
| **Зорилт 2.2** Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх ЭМЯ-аас баталсан арга хэмжээний төлөвлөгөө, Дүүргийн ИТХ-аас баталсан НЭМ-ийн төслийн дагуу хэрэгжүүлэн ажиллах /АХ-2.2.1, 2.2.2, 2.2.14, НЗДҮАХ-2.1., СХДЗДҮАХ-2.1/ | | | | | | | |
| 2.2.1 | Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх | Орон нутгийн төсөв 2.0 | Хэрэгжилтийн хувь | 93% | 95% | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд 8 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж ажиллаа. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 85%-тай байна.<br><br>НЭМ-ийн баг, Өсвөр үеийн кабинет хамтран харьяа сургуулийн өсвөр насны сурагчдад “Эрүүл ирээдүй тэдний гарт” цуврал лекцийг зохион байгуулж нийт 475 хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгосон байна.<br><br>Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн хүүхдийн эмч нар, хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг, нийгмийн эрүүл мэндийн алба хамтран ӨЭМТ-ийн эмч нарт зонхилон тохиолдох хүүхдийн өвчлөлийн үед авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэлтийн мэдлэг сайжруулах чиглэлээр сургалтын удирдамж боловсруулж сар бүрийн 2 дахь 7 хоногт сургалт зохион байгуулж байна. Одоогоор 2 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж 35 өрхийн эмчийг хамруулаад байна. | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр нэгдсэн эмнэлгийн холбогдох тасаг, албадын ахлахууд, ӨЭМТ-өөс Төв, Толгойт бүсийн дарга нар, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд оролцсон уулзалт зохион байгууллаа.<br><br>Уулзалтаар сүүлийн 3 жилийн эх нярайн таагүй үзүүлэлтийн мэдээ, шалтгаан, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн. Цаашид эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр ӨЭМТ-ийн жигд оролцоог хангах, хариуцлагыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх тал дээр шийдвэрт хүрлээ.<br><br>Тус уулзалтаар хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг ӨЭМТ-д шилжүүлж хянахаар нөхөн үржихүйн кабинетад хянагдаж буй 1783 жирэмсэн эмэгтэйн 3% буюу 53 жирэмсэн эмэгтэйг эхний байдлаар ӨЭМТ-ийн хяналт руу шилжүүллээ.<br><br>Цаашид хянагдаж буй жирэмсэн эмэгтэйчүүдийн 30%-ийг ӨЭМТ-д шилжүүлж хянахаар шийдвэрт хүрлээ. Мөн гэрийн төрөлтийн тохиолдлыг бууруулах зорилгоор 36 долоо хоног хүрсэн жирэмсэн эмэгтэйчүүдэд 40 долоо хоног хүртэл ӨЭМТ долоо хоног бүр гэрийн эргэлт хийж таагүй үзүүлэлтээс сэргийлэхийг зөвлөмж болголоо. Нийслэлийн ЭМГ-ын даргын А/94 Хариуцлагатай сонголт аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулж хамтран ажиллахад санал солилцлоо. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Жирэмсний хяналтаар үйлчлүүлж буй жирэмсэн эмэгтэйчүүдэд кабинет тус бүр шаардлагатай тохирсон мэдээллийг өгч нийт 6675 жирэмсэн эмэгтэйд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан байна.<br><br>Жирэмсэн, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд, өсвөр үед чиглэсэн видео бичлэгийг Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч Ж.Пүрэвжаргал 3 удаагийн Сонгинохайрхан дүүргийн багтай хамтран бэлтгэлээ. Видео хандалт тоо-45000 | |
| 2.2.2 | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 0.5 | Хэрэгжилтийн хувь | 90% | 95% | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж ажиллаа. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 85%-тай байна.<br><br>СХНЭ дархлаажуулалтын цэгт Наранманал, Отгондолоонбурхан-1, Гурван цүүр, Отгондолоонбурхан-2, Батцэцэн, Гурванжаргал хайрхан-1, Эхэн босго, Энх-Элбэрэл-2 нийт 8 ӨЭМТөвүүдийн дархлаажуулалтыг хариуцан хийж тайланг сар бүр тооцон ажиллаж байна. Үүнд:<br>• Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг вакцин – 1439 хүн тун<br>• Халдварт саагийн эсрэг вакцин (уудаг) – 1434 хүн тун<br>• Халдварт саагийн эсрэг вакцин (тарьдаг) – 478 хүн тун<br>• Тавт вакцин – 1434 хүн тун<br>• Пневмококкийн эсрэг вакцин – 1499 хүн тун | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Гепатит А эсрэг вакцин – 1103 хүн тун<br>Хагас жилийн тайлангийн хугацаанд 7387 хүүхэд хамрагдахаас 7204 хүүхэд буюу 97.52% товлолтын дархлаажуулалтанд хамрагдсан, 183 хүүхэд буюу 2.47% нь өрхөөс хүүхэд шилжин явах, шалгаан нь тодорхойгүй, товлолтын дархлаажуулалтаас санаатай болон санамсаргүй байдлаар хамрагдаж чадаагүй хоцорсон байна.<br><br>Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 12 удаа зохион байгуулж 1706 иргэнийг хамруулсан. Үүнээс сүрьеэгийн халдвар оношлогдсон 4 тохиолдолд очиж хавьтлын үзлэг зохион байгуулсан. Нийт урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдээс 28 хүнээс цэрний шинжилгээ, 32 далд халдвар илрүүлж эмчилгээнд, 7 хүний нян судлалын шинжилгээнээс сүрьеэгийн халдвар илрүүлсэн.<br><br>Олон нийтэд сүрьеэ өвчнөөс сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж 200 хүнд мэдээлэл өглөө. Мөн дүүргийн хэвлэл мэдээллийн албатай хамтран сүрьеэ өвчний талаар мэргэжлийн эмчийн зөвлөгөөг хүргэж нийт 5763 хүн үзсэн. ӨЭМТ-ийн эмч болон тасгийн эмч нарт сургалт зохион байгуулж 45 хүнийг хамрууллаа.<br><br>БЗДХ-ын кабинетаар эхний хагас жилд нийт 5256 амбулаторийн үзлэг хийсэн. Үзлэгээр нийт 332 БЗДХ-ын шинэ тохиолдол бүртгэгдсэн. Амбулаторийн үзлэг, халдварын илрүүлэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өссөн дүнтэй байна. Үзлэг 33%-иар, халдварын тохиолдол 26%-иар өссөн байна.<br><br>Үүнээс тэмбүүгийн халдвар 146 (44%), заг хүйтэн 66 (19.8%), трихомониазын халдвар 78 (23.4%), бусад халдвар 42 (12.6%) тус тус илрүүлсэн.<br><br>Нийт 247 хавьтал илрүүлж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. | |
| 2.2.3 | Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 0.5 | Хэрэгжилтийн хувь | 90% | 95% | Арга хэмжээний хүрээнд 10 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гаргаж ажиллаа. Хагас жилийн байдлаар 65%-ийн биелэлттэй байна.<br><br>Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг мэдээ мэдээлэл, зурагт видео, брошур нийт 9 танилцуулгыг боловсруулан СХНЭ пэйж хуудас, хүлээлгийн заалны лед дэлгэцээр дамжуулан эмнэлгийн ажилчид болон иргэдэд хүргэж байна. Пэйж хуудасны нийт хандалтын тоо 10,235 мянга. Нийт цахим сүлжээнд мэдээлэл авч буй иргэдийг хүйсээр үзвэл 79,1 хувь эмэгтэй, 20,9 хувь эрэгтэй байна.<br>Хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлсэн гэр бүл нь архины асуудалтай, хүүхдийг асран хамгаалах үүргээ хангалттай биелүүлээгүй эцэг, эхчүүдийн талаар Хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багт 4 хүүхдийн мэдээллийг өгч холбон зуучилсан. | 65% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.4 | Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 0.5 | Хэрэгжилтийн хувь | 95% | 100% | Арга хэмжээний хүрээнд 17 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж хагас жилийн байдлаар 75%-ийн биелэлттэй байна.<br><br>2025 оны хагас жилийн байдлаар нийт 570 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаас гүйлсэн булчирхайн архаг болон цочмог үрэвсэлтэй 24%, шүд хорхойтох өвчин 58%, бусад өвчлөл 12% хүүхэд илэрсэн. Нийт өвчлөлийн 46 хувийг эрүүлжүүлсэн байна.<br><br>Сонгинохайрхан дүүргийн 278 өсвөр насны хүүхдүүдээс “Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн байдал” сэдэвт 3 хэсэгт судалгааг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан багш нараас авч судалгааны боловсруулалт хийж ажиллаж байна.<br><br>СХНЭ-ийн Хүүхдийн Яаралтай тусламжийн тасгаар үзүүлээд буцсан болон НТТТ-өөр үзүүлсэн хүүхдүүдийн мэдээллийг СХНЭ-Хүүхдийн мэдээ гэсэн группт байршуулж тухай бүрд нь ӨЭМТ мэдээлэл авч гэрийн эргэлт хийн ажиллаж байна. ӨЭМТ-үүд мэдээлэл хүлээн авснаас хойш 24-72 цагийн дотор гэрийн эргэлт 21,2%-тай хийсэн байна.<br><br>СХНЭ- Хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлж буй суурь өвчлөлтэй хүүхдүүдийг бүртгэж өрхийн эрүүл мэндийн төвд мэдээлж хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэлт явагдаж байна. Хагас жилийн байдлаар 14 хүүхдийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлж байна. | 75% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны хагас жилийн байдлаар суурь өвчтэй нийт 12 хүүхэд бүртгэгдэж ӨЭМТ-д мэдээллийг хүргүүлэн, хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлж байна.<br><br>2025 оны хагас жилийн байдлаар 48 хүүхэд идэвхтэй хяналтад байснаас шинээр 13 хүүхдийг хяналтанд авсан байна. Үүнээс амбулатори I- 6, амбулатори II- 7 хүүхдийг шинээр хяналтанд авсан байна.<br><br>2025 оны хагас жилийн байдлаар Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг нь Амбулотори I-2473, амбулатори II-2495, Өсвөр үеийн кабинет-887 хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Манай эмнэлэг нь хүүдийн зүрх судас, мэдрэлийн эмгэг судлал, нярайн эмгэг судлал болон хүүхдийн мэс засал, урологи, нярайн түнхний эхо зэрэг нарийн мэргэжлийн эмчийн нарын үзлэгийг 2025 оны 03 дугаар сараас хуваарийн дагуу хийж эхэлсэн.<br><br>2025 оны хагас жилийн байдлаар осол гэмтэл болон ахуйн осол гэмтлээс сэргийлэх үүднээс 16 удаа мэдээлэл түгээсэн байна. Үүнээс зурган хэлбэрээр 12 удаагийн, бичлэг хэлбэрээр 4 удаагийн богино бичлэгийг хийж өөрийн эмнэлгийн цахим хуудсаар мэдээллийг хүргүүлсэн ба 2850 хандалт авч, 15 удаа бусдад хуваалцсан байна.<br><br>Жирэмсний хяналтад ирж буй ээж, аав нарт жирэмсэн ээжид туслахуй, төрөх үеийн бэлтгэл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэдвээр зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилладаг. Өсвөр насны жирэмсэн ээж нарт сэтгэлзүйн болон өсвөр үеийн жирэмслэлтийн онцлог сэдвээр 52 жирэмсэн охидод зөвлөгөө өгсөн байна.<br><br>НЭМ-ийн баг, Өсвөр үеийн кабинет хамтран харьяа сургуулийн өсвөр насны сурагчдад "Эрүүл ирээдүй тэдний гарт" цуврал лекцийг зохион байгуулж нийт 430 хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгосон байна. | |
| 2.2.5 | Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 1.0 | Хэрэгжилтийн хувь | 90% | 95% | Арга хэмжээний хүрээнд 11 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахаар тусгасан. Хагас жилийн байдлаар 75%-ийн биелэлттэй байна.<br><br>Сэтгэцийн кабинет, яаралтай түргэн тусламжийн тасаг, дотрын тасаг, мэдрэлийн тасаг, нөхөн үржихүйн кабинет, хүүхдийн тасаг, өсвөр үеийн кабинет, дотоод шүүрлийн кабинет, хавдар хөнгөвчлөхийн тасаг, гэмтлийн тасаг, дэгдээхэй тасагт хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгчид нийт 282 удаагийн ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө тусламжийн үйлчилгээ үзүүлсэн.<br><br>Ажилтнуудын ажлын байран дахь сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үүднээс сэтгэл зүйч бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг өгч эхний хагас жилд 4 тасагт ажиллаж 87 ажилтанд ажлаас халшрах хам шинжээс сэргийлэх, стрессийг зөв зохицуулах, мэдрэмжээ илэрхийлэх зэрэг сэдвээр сургалт, зөвлөгөө өглөө. | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сэтгэцийн өдрийн эмчилгээнд нийт 157 иргэнийг хамруулсан.<br><br>Сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсролыг хүүхдүүдэд олгох чиглэлээр 7 сургуулийн нийт 464 хүүхдэд танхимын сургалт зохин байгууллаа.<br><br>Хавдар хөнгөвчлөх эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл заслын үйлчилгээнд нийт 12 хүнийг хамруулсан. | |
| 2.2.6 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 0.5 | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж ажиллаа. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 80%-тай байна.<br><br>Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа, өдөрлөг арга хэмжээнүүдийг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж эхний хагас жилийн байдлаар 29 сургалт, сурталчилгааны ажил зохион байгууллаа. Цахим хэлбэрээр нийт 187 удаагийн мэдээлэл байршуулсан байна. Зураг постер хэлбэрээр 147, видео хэлбэрээр 15 удаагийн сурталчилгааны материал оруулж нийт 432 мянган хүнд хүрч, 2,3 сая удаагийн үзэлт авсан байна.<br><br>Сургалт, өдөрлөг арга хэмжээнд нийтдээ 2964 иргэнийг хамруулсан байна. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цахим хэлбэрээр “Эмч зөвлөж байна” контентыг үргэлжлүүлэн бэлтгэж Чихрийн шижин өвчин, харшил, осол гэмтлээс сэргийлэх, артерийн даралт ихсэх өвчнөөс сэргийлэх чиглэлээр зөвлөмж бэлтгэж нийт 113 мянган хүнд хүрсэн байна. | |
| 2.2.7 | Элэг бүтэн Монгол арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 0.5 | Хэрэгжилтийн хувь | 98% | 100% | Элэг бүтэн Монгол арга хэмжээний хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж ажиллаа. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна.<br><br>Элэгний В вирусийн эсрэг вакцин, хүүхдийн товлолт вакцины тухай мэдээллийг эмнэлгийн пэйж хуудсаар иргэдэд сурталчилж 2 удаагийн мэдээлэл байрлуулж 4.5 мянган хүнд хүрсэн.<br><br>Дэмжих төвийн эрт илрүүлэгд 3796 иргэн хамрагдсан. Үүнээс В вирусийн халдвартай 154, С вирусийн халдвартай 210 иргэн бүртгэгдсэн байна.<br><br>Халдварын сэргийлэлт хяналт талаарх ерөнхий ойлголт сэдэвт нийт 13 сургалтыг эмнэлгийн шуурхай хуралдаан, эмч нарын яриа, тасаг нэгжүүдэд нийт давтагдсан тоогоор 293 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан байна. | 100% |
| 2.2.8 | Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 2.0 | Хэрэгжилтийн хувь | - | 90% | Арга хэмжээний хүрээнд 10 үйл ажиллагаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай биелсэн. | 95% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Стрессгүй ажлын байрыг бий болгох үүднээс эмнэлгийн сэтгэл зүйч ажилтнуудад ажлаас халшрах хам шинжээс сэргийлэх, стрессийг зөв зохицуулах зэрэг сэдвээр цуврал сургалтуудыг зохион байгуулж, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг. 2025 оны эхний хагас жилд 5 нэгжид ажиллаж 87 ажилтанд сэтгэл зүйн эрүүл мэндийн сургалт орж, сэтгэл заслын богино хэмжээний аргуудыг ажилчдын дунд хэрэгжүүлсэн байна.<br><br>Байгууллагын ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж лабораторийн шинжилгээ, нарийн мэргэжлийн 11 эмчийн үзлэг, хэвлийн ЭХО, эмэгтэйчүүдийн ЭХО, шаардлагатай тохиолдолд КТГ, улаан хоолой, ходоодны дуран, хавдрын маркер зэргийг үзэж тодорхойлдог. 2025 онд нийт 460 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж хамралт 83.6%-тай орсон байна. Өнгөрсөн оны тоотой харьцуулахад 6.3%-иар өссөн дүнтэй байна. Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн үзлэгээр үзлэгт орсон бүх ажилчдыг хамруулж эрүүл мэндийн эрсдэлт тодорхойлогдсон ажилтныг эмчийн хяналтад авдаг. Ажилтны эмчийн хяналтад 97 ажилтныг бүртгэн авч дараагийн нарийвчилсан шинжилгээнд хамруулж байна.<br><br>2025 онд 171 хүнд зөвлөгөө өгч артерийн даралт ихсэх өвчнөөс сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгсөн байна.<br>Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчлан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагуудад очиж сургалт зохион байгуулах ажлыг 3 удаа зохион байгуулж 241 хүнийг хамруулсан.<br><br>Эрт илрүүлгийн нэгжээр 2025 оны эхний 5 сард 3796 хүн хамрагдсанаас 1522 нь эрэгтэйчүүд буюу 40%-ийг эзэлж байна.<br><br>Цахим хэлбэрээр эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар 2 удаагийн мэдээлэл түгээс 4000 хүнд хүрсэн байна. | |
| 2.2.9 | Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв 0.5 | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Эрүүл шүд арга хэмжээний хүрээнд 8 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж ажиллаа. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 50%-тай байна.<br><br>Нэгдсэн эмнэлгийн Амбулатори I-Шүдний кабинетын эмч, мэргэжилтнүүд амны хөндийн эрүүл мэндийн Дэлхийн өдрөөр үйлчлүүлэгчид, ажилтнууд, "Бяцхан доктор" ажилчдын хүүхдийн цэцэрлэгийн багачуудад R.O.C.S Mongolia байгууллагатай хамтран зөвлөгөө мэдээлэл өгч, шүдний оо, сойзны бүрдлийг багачуудад, ажилчдад бэлэглэлээ.<br><br>62-р сургуулийн 3-р ангийн сурагчдад амны хөндийн эрүүл мэнд, шүд угаах зөв аргын талаар сургалт зохион байгуулж 62 хүүхэд хамрагдлаа.<br>Шүдний эмчтэй хамтран иргэдэд зориулсан амны хөндийн эрүүл мэндийг сахих видео зөвлөгөө бэлтгэж пэйж хуудсанд байршууллаа. Мөн постер байршуулж олон нийтэд | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчиллаа. Нийт 5.9 мянган хүн үзсэн байна. | |
| **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | | | | |
| **Зорилт 2.3.** Хүн амын эрүүл мэндийн байдал болон эмнэлгийн орчны халдвар түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах. /АХ-2.2.2, НЗДҮАХ-2.1**,** СХДЗДҮАХ-2.1/ | | | | | | | |
| 2.3.1 | Эмнэлгийн халдваргүйтгэл ариутгалын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн ажиллах | Байгууллагын төсөв 10.0 | Дезкамер байрлуулсан байх | - | 1 | Төлөвлөгөөт хугацаанд | - |
| 2.3.2 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний холбоотой халдварын эрсдэлийг бууруулах чиглэлээр тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг арилгах арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх | - | Бүртгэгдсэн тохиолдлын тоо | 6 | 4 | Эмнэлгээс шалтгаалсан халдварын нийт 10 сэжигтэй болон 8 батлагдсан тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс судасны гуурстай холбоотой – 1, зохиомол амьсгалын аппараттай холбоотой – 2, тарилгын аюулгүй байдлын зөрчилтэй холбоотой – 1, улаанбурхан халдварт өвчний тохиолдол – 4 байсан болно. Эмнэлгээс шалтгаалсан халдварын тохиолдол нэмэгдсэн нь Улаанбурхан халдварт өвчний дэгдэлттэй 50 %холбоотой байна | 50% |
| | | | Тандалтын хувь | 87.7% | 90% | Дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу нийт 31 удаагийн дэмжлэгт хяналт хийсэн. Хяналтын явцад 62 илэрсэн зөрчил бүрт хариу арга хэмжээ арилгуулах зөвлөмжийг 8 тасагт хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 86.5% байна**.**<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээний тандалт 2 хэлбэрээр хийгдсэн.Үүнд:<br>Идэвхгүй тандалт – Тасаг нэгж дээр өдөр бүр эмч, сувилагч, туслах сувилагч нар үзэн тэмдэглэл хөтлөн ажилладаг.<br>Идэвхитэй тандалтыг – 56 хүнд 120 өдөр Хийсэн ба тандалтын дундаж үнэлгээ – 88.2% | 87.5% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалтын тоо | 60 | 40 | Халдвараас сэргийлэх, хяналт, дархлаажуулалтын чиглэлээр 21 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 521 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. | 51 % |
| | | | Хамрагдсан хүний тоо | 2057 | 1200 | Давхардсан тоогоор 521 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан хэрэгжүүлсэн. | 43.4% |
| | | | Мэдлэгийн дундаж түвшин | 83.8% | 90% | Тайлангийн хугацаанд нийт 21 төрлийн сургалт амжилттай зохион байгуулсан. Эдгээр сургалтад давхардсан тоогоор 521 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан бөгөөд сургалтын дараах мэдлэгийн дундаж үнэлгээ 88 **%** байна. | 88% |
| 2.3.3 | Нян судлалын лабораторийн шинжилгээний чадавхыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж ЭТҮХХ болон халдварын илрүүлэг шинжилгээг сайжруулж нян судлалын дүгнэлт мэдээллийг сар бүр удирдлагын шуурхайд танилцуулж ажиллах. | - | Цусны ариун чанар, эрүүл зүйн агаарын шинжилгээ хийх | 0% | 100% | Нян судлалын лабораторид нийт 16 төрлийн 4046 сорьц цуглуулж шинжилгээ хийсэн. Үүнээс:<br>• Эрүүл зүйн шинжилгээ – 52 сорьц (1.28%)<br>• Эмнэлзүйн шинжилгээ – 3994 сорьц (98.72%)<br>  ○ Амбулаторийн сорьц – 2166 (62.8%)<br>  ○ Хэвтэн эмчлүүлэгчдийн тасгийн сорьц – 1280 (37.2%)<br><br>Эрүүл зүйн шинжилгээ<br><br>Эрүүл зүйн шинжилгээг халдварын өндөр эрсдэлтэй 7 тасаг, нэгжид улирал тутамд хийхээр төлөвлөж, эмнэлгийн эрхэлсэн дэд захирлаар батлуулсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд нийт 52 эрүүл зүйн шинжилгээ хийснээс:<br>• Агаарын шинжилгээ – 2 сорьц (3.9%)<br>• Арчдасны шинжилгээ – 50 сорьц (96.1%)<br>Шинжилгээнүүдийн дүнгээр:<br>• 18 сорьцноос (34.6%) эмгэг төрөгч илэрсэн бөгөөд тухайн тасаг, нэгжид дотоод бичгээр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Илэрсэн эмгэг төрөгчийн ангилал:<br>• Staphylococcus aureus – 3<br>• Klebsiella spp. – 2<br>• Methicillin-resistant Staphylococcus aureus (MRSA) – 13 | |
| 2.3.4 | Ундны усанд pH, булингар, E.Coli нянгийн тоог итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх | Байгууллагын төсөв 1.0 | Хяналтын хувь | 80% | 85% | Төлөвлөгөөт хугацаанд | - |
| 2.3.5 | Томуугийн улирлын хугацаанд зонхилон тохиолдох амьсгалын замын синцитал вирусийн тархалтад тандалт судалгаа хийх | - | Тандалт судалгаан хамруулсан хүний тоо | - | 260 | Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд томуу, томуу төст өвчний улирлын сэжигтэй 162 тохиолдолд томуу болон томуу төст вирусын 5 төрлийн үүсгэгч (Flu A, B, RSV, Adenovirus, M. pneumoniae)-ийг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийснээс 55 сорьцод буюу нийт | 62.3% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 33.9%-д нь 6 төрлийн вирус илэрсэн ба тэдгээрийг ангилж үзвэл:<br>- RSV – 26 (4.4%)<br>- Adenovirus – 5 (2.7%)<br>- Influenza A/B – 14 (7.2%)<br>- Influenza A – 7 (3.8%)<br>- Influenza B – 3 (1.6%) байв. | |
| 2.3.6 | Антибиотикийн мэдрэг чанар, вирус судлалын шинжилгээнд дүгнэлт хийж, хяналт тавих | - | Хяналтын тоо | 12 | 12 | Антибиотикийн тэсвэржилтийн байдлыг 2024 оны хагас жилийн үзүүлэлттэй харьцуулахад 2025 оны хагас жилд тэсвэржилттэй тохиолдлын хувь 53.1%-аас 22.7% болж буурсан нь нийт 6415 сорьцод хийсэн мэдрэг чанарын шинжилгээний үр дүнд илэрч, тасаг нэгжүүдийн бичил биетний хяналт, зөв зохистой хэрэглээний үр нөлөөг харуулж байна.<br>Антибиотикийн мэдрэг чанарт дүн шинжилгээ хийснээс тэсвэржсэн үүсгэгчийн тоо 4665 буюу 77.3%, мэдрэг үүсгэгчийн тоо 1750 буюу 22.7% байна. | 5 |
| | | | Үнэлгээний хувь | 100% | 100% | | 65% |
| 2.3.7 | Гарын эрүүл ахуйг сахих 21 хоногийн аян зохион байгуулах | Байгууллагын төсөв 1.0 | Аяны тоо | - | 1 | Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын 'Гарын эрүүл ахуйн өдөр'-тэй холбогдуулан “Эрүүл гар – Энгийн хариуцлага” аяныг зохион байгуулж, нийт 17 тасгийг хамруулсан.<br>Аяны хүрээнд гарын эрүүл ахуйн мэдлэг, дадлыг үнэлж шилдэг тасаг шалгаруулах, мөн 'Гар угаахын ач холбогдлын талаар' рийл танилцуулга хийх зэрэг үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ. Шалгаруулалтад Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг болон Өвчтөний нөхөн сэргээх эмчилгээний тасаг тэргүүн байрт шалгарсан.<br>Ажилтнуудын гарын эрүүл ахуйн мэдлэг, дадлын дундаж түвшин 88.2% байсан бөгөөд ангиллаар нь авч үзвэл: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Эмч – 86.2%<br>- Сувилагч – 89.03%<br>Тусгай ажилтан – 77.7% тус тус эзэлж байна. | |
| **Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа** | | | | | | | |
| **Зорилт 2.4.** Гамшгаас хамгаалах хуулийн хүрээнд хариу арга хэмжээ зохион байгуулах /АХ-2.2.10, НЗДҮАХ-1.1, СХДЗДҮАХ-1.1/ | | | | | | | |
| 2.4.1 | Гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийх, нөөц, хэрэгслийн бүрдлийг нэмэгдүүлэх | Байгууллагын төсөв 19.0 | Гамшгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нэгдсэн эмнэлгийн захирлын 2024 оны 03 сарын 12-ний өдрийн А/24 тоот тушаалаар Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг тодотгол хийж шинэчлэн баталсан.<br><br>Гамшгийн үеийн бэлэн байдлын халдваргүйтгэл, ариутгалын бодисын нөөцийг бүрдүүлэн хяналт тавьж байна. Ариутгалын бодис 17 литр, 37 таблет, 337 ширхэг флакон, нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл 96,181 ширхгийн нөөцтэй байна.<br><br>Хээрийн зориулалттай аяны майхан 1, хамгаалах хувцас хэрэгсэл 14 хүний нөөцтэй. Хэрэгжилт 83.3% | 100% |
| | | | Аяны майхан | - | 2 | | 1 |
| | | | Хамгаалах хувцас, хэрэглэл | - | 20 | | 14 |
| **ХОЁРДУГААР ХЭСЭГ.<br>ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| **Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго 3:** Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. / АХ-2.2.4, НЗДҮАХ-2.1.5.3, НЗДҮАХ-2.1.5, ХАХТ-2.1.5.2, МУХТЖҮЧ-2.2.8, НСХДЗДҮАХ-2.1/ | | | | | | | |
| **Хүний нөөц, хөгжлийн үйл ажиллагаа** | | | | | | | |
| **Зорилт 3.1.** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүний нөөцийг зохистой төлөвлөн, эрх зүйн баримтыг бүрдүүлэн, хэрэгжүүлэн ажиллах /АХ-2.2.29, НЗДОҮАХ 2.1, 2.1.5, НЭМГТ, СДЗДОҮАХ 1.1, 2.5, 4.3/ | | | | | | | |
| 3.1.1 | Ажилтны мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, шинэ оношилгоо, эмчилгээ, техник технологийн орчинд | Орон нутгийн төсөв 100.0 | Гадаад улс оронд нарийн мэргэшлийн сургалтад хамруулсан ажилтны тоо | 11 | 15 | - Мэс заслын тасгийн эмч Ганбатын Жаргалсайхан БНХАУ-ын Шанхай хотын Чойжин эмнэлэгт онол практикийн сургалтад | 11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр гадаад, дотоодын сургалтуудад хамруулах | Байгууллагын төсөв 128.0 | Олон улсын сертификаттай сургалт, туршлага солилцох хөтөлбөрт хамрагдсан ажилтны тоо | 12 | 25 | - Дотор, мэдрэл, гэмтэл, насанд хүрэгчдийн эрчимт эмчилгээний болон мэс заслын чиглэлээр тусламж үйлчилгээнд сэргээн засах эмчилгээг нэвтрүүлэхийн хүрээнд Япон улсын Фүжима коген эмнэлэгт 7 хоногийн сэргээн засахын сургалтад 4 эмч | 11 |
| | | | Дотоод сургалтын тоо | 6 | 10 | - БНСУ-д ‘’Умайн хүзүүний хавдрын илрүүлэг шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглах’’ сургалтад 2 эмч | 6 |
| | | | Удирдах ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан хүний тоо | 25 | 75 | - Шааньси мужийн Анкан хотод зохион байгуулагдах ‘’Глобал эрүүл мэндийн хамтын нийгэмлэгийг байгуулахад уламжлалт ангаах ухааны шинэ боломжуудыг хуваалцах нь’’ сургалтад 1 эмч<br>- Солонгос улсын Сөүл хотноо ‘’Imkasid 2025 seoul’’ дурангийн олон улсын сургалтад 1 эмч<br>Япон улсад болох Олон улсын Радиологийн сургалтад 2 эмч Итали улсын Милано хотын ”San Donato’’ эмнэлэгт мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 эмчийг 100% цалинтай хамтран ажиллана.<br>- 2025 оны хагас жилийн байдлаар Төрөлжсөн мэргэжлийн хаврын сургалтад 5 эмч, 5 сувилагч төрийн сангаар 100% цалинтай хамруулан ажилласан байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сургалтын хэрэгцээ, чадавхад суурилсан багц цагийн сургалтын 5 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 249 хүн хамруулан ажилласан байна. | 45 |
| 3.1.2 | Эрдмийн болон мэргэшлийн зэрэгтэй, мэргэшсэн эмч, эмнэлгийн | Байгууллагын төсөв 10.0 | Магистрын сургалтад хамруулсан ажилтны тоо | - | 4 | • Анагаахын болон сувилахуйн АШУҮИС-н Сувилахуйн сургууль, Этүгэн ИС-н Сувилахуйн сургууль, Ач анагаах ухааны сургууль / эмч /, Үндэсний техникийн их | 3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжилтний эзлэх хувийг нэмэгдүүлэх | | Ахлах зэрэгтэй ажилтны тоо | 36 | 43 | сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах ажилласан.<br>• АШУҮИС, АШУҮИС-н Сувилахуйн сургуулийн ажил олгогчийн өдөрлөг оролцон 2 ангийн 20 оюутанд урилга өгсөн. Ажил олгогч байгууллага, ЭИС-ийн хамтарсан уулзалтад САД, САЗ, ХНХА-ны мэргэжилтэн оролцож, танилцуулга хийж, төгсөх ангийн 9 оюутанд батламж олгосон. ЭИС-ийн төгсөлтийн баярт диплом гардуулах үйл ажиллагаанд оролцлоо. Нийт төгсөх ангийн 14 оюутанд эмнэлэг сувилахуйн албаны танилцуулга, батламж гардуулан.АШУҮИС-н Сувилахуйн сургуулийн 1,2 дамжааны 52 оюутан хэвтэн эмчлүүлэх 8 тасагт дадлага сургалт хийн ажилласан.<br>• НЭМГ-аас зохион байгуулсан “Сувилахуйн тусламж, үйлчилгээг танилцуулах” өдөрлөгт СХНЭ-ийн ЭЭДЗ, Сувилахуйн албаны дарга, Сувилахуйн албаны арга зүйч, тасгийн арга зүйч, ХНХА, СССҮХА-ны мэргэжилтнүүд багаараа амжилттай оролцлоо. Арга хэмжээнд Эрүүл мэндийн 10 байгууллагын СЭОД, САД нар болон нийт 144 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад мэргэжилтнүүд, Сувилахуйн чиглэлээр суралцдаг 7 сургуулийн 79 оюутан мэдээлэл авч, үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцож хамтран ажилласан ба 5 оюутанд батламж гардуулсан.<br>Этүгэн ИС-ын 1,2 дамжааны Этүгэн ИС-н Сувилахуйн сургууль 1,2 дамжааны оюутнуудтай багш шавийн гэрээ байгуулан. Этүгэний уламжлалт анагаах ухааны | 55 |
| | | | Тэргүүлэх зэрэгтэй ажилтны тоо | 23 | 29 | | 25 |
| | | | Зөвлөх зэрэгтэй ажилтны тоо | 1 | 1 | | 2 |
| | | | Эрдмийн болон мэргэшлийн зэрэгтэй ажилтны хувь | 18% | 22% | | 22% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээний ангийн 26 оюутан харилцааны ур чадварын дадлага хийсэн. | |
| 3.1.3 | “Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг”-ийг сургах, чадавхжуулах, Байгууллагын 2026-2030 оны Хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулах | Байгууллагын төсөв 18.0 | Хөгжлийн хөтөлбөр | 2022-2026 | 100% | Төлөвлөгөөт хугацаанд | - |
| | | | Сургалтад хамруулж, чадавхжуулсан хүний тоо | - | 11 | | - |
| | | | Гадаадад туршлага судалсан хүний | - | 6 | | - |
| | | | Дотоодод туршлага судалсан хүний тоо | - | 5 | | |
| 3.1.4 | Шинээр ажилд орсон сувилагчнарыг шинэ сувилагчийн хөтөлбөрт хамруулах | - | Шинээр ажилд орсон сувилагчаас сургалтад хамрагдсан хувь | - | 30% | Шинэ ажилтын чиглүүлэх номыг 2024 онд хэвлүүлэн тус номыг шинээр ажилд орсон ажилчдад олгодог бөгөөд 2025 оны эхний улиралд албатай хамтран нийт 173 шинэ ажилчдад чиглүүлэх сургалт хамруулсан. | 100% |
| | | | Шинэ сувилагчаас үзүүлсэн тусламж, үйлчилгээтэй холбоотой таагүй ба ноцтой тохиолдлын тоо | - | - | | |
| 3.1.5 | Эм зүйчдийг клиник эм зүйчийн мэргэшүүлэх сургалтад хамруулах | - | Мэргэшсэн клиник эмч зүйчийн тоо | 3 | 5 | 2025 оны хагас жилийн байдлаар Төрөлжсөн мэргэжлийн хаврын сургалтад 5 эмч, 2 клиник эмч, 5 сувилагч төрийн сангаар 100% цалинтай хамруулан ажилласан байна. | 5 |
| | | | Шинээр мэргэшсэн клиник эмч зүйчийн сургалтад хамрагдсан эм зүйчийн тоо | 1 | 2 | | 2 |
| 3.1.6 | Эмнэлгийн ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын | Байгууллагын төсөв | Ажилтны тоо | 20 | 25 | - Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлдэг үр дүнгийн урамшууллын журмын шинэчлэн боловсруулахаар эмч, сувилагч, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэл чанар бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор амьдралын чанарыг дээшлүүлж орон сууцны урьдчилгаанд дэмжлэг үзүүлэх | 50.0 | | | | тусгай мэргэжилтний шалгуур үзүүлэлтийн боловсруулан 2025 оны 05 дугаар 29-ний өдөр анхны санал хэлэлцүүлэн алба, тасгийн эрхлэгч нарын саналын тусгах ажлыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албанд боловсруулан ажиллаж байна.<br>- 2024 оны 12 дүгээр сарын......-ний Засгийн газрын ….. дугаар тогтоолоор үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн ажилласан.<br>Олон улсын эмч, сувилагч нарын баярыг тэмдэглэн нийгмийн баталгааг хангах амьдралын чанарыг дээшлүүлэх орон байрны нөхцөлийн дээшлүүлэх зорилгоор 5 эмч 5 сувилагч нарт 30 сая төгрөгийн байрны урьдчилгааг олгон ажиллалаа. | |
| 3.1.7 | Ажилтнуудын ажлын идэвхийг тогтмол сэргээхэд чиглэсэн ажил, мэргэжлийн болон ур чадварын уралдаан, тэмцээнийг тогтмол явуулах, урамшуулах | Байгууллагын төсөв 50.0 | Арга хэмжээний тоо | 10 | 15 | 2025 оны хагас жилийн байдлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эмнэлгийн хэмжээнд хоёр удаа зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд нийт 34 судалгааны бүтээл ирүүлсэн байна. Үүнээс эмч нарын дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээний ажлын хүрээнд 35 эмч оролцож, 19 бүтээл ирүүлсэн бол сувилагч нарын дунд зохион байгуулсан арга хэмжээнд нийт 15 судалгааны ажил ирүүлсэн байна. Мөн сувилагч, тусгай мэргэжилтэн нарын дунд танхимын сургалтыг улиралд 1 удаа нийт 2 удаа ЭМТҮЧАБА, ХСХДА, ХНХА, СССХҮА, ИТМТА хамтран зохион байгуулж сургалтад 17 тасгийн 173 сувилагч, тусгай мэргэжилтэн, туслах сувилагч оролцсон.<br>Хүүхдийн эрчимт эмчилгээний тасагтай хамтран доорх гардан үйлдлийг хийж гүйцэтгэхэд сувилагчийн оролцоо үзүүлэх | 90% |
| | | | Хамрагдсан хүний тоо | 120 | 150 | | 233 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
